



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

*Улсын Их Хурлын Байгаль орчин, Хүнс, хөдөө аж ахуйн
Байнгын хорооны саналын дагуу хийсэн аудитын тайлан*

МОНГОЛ ОРНЫ УСНЫ НӨӨЦИЙН ХАМГААЛАЛТ, АШИГЛАЛТЫН БАЙДАЛ



**Усны асуудал эрхэлсэн төрийн байгууллагуудын нэгдсэн
бүтэц, удирдлага, зохион байгуулалт оновчгүй, ажлын уялдаа
холбоо хангалтгүй байна**

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн жагсаалт	3
ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....	4
Захирал Д.Ганбилэг	Бүлэг 1 Монгол орны гадаргын болон газрын доорх усны нөөцийг бүрэн тогтоогоогүй байна	
Аудитын менежер Х.Баярмаа	Усны нөөцийг бүрэн тогтоогоогүй байна.....	5
Ахлах аудитор Г.Цэдэнбалжир	Усны тооллого хийж байгаа боловч дүн шинжилгээ хийгдэхгүй байна	6
Шинжээч Ц.Цолмон Т.Батзориг Л.Авирмэд	Хүн амын унд, ахуйн хэрэглээний ус хангамжийн нөөцийг зүй зохистой тогтоож чадахгүй байна	6
	Усны нөөцийг хамгаалалтад авч байгаа ч түүний дэглэмийг мөрдөхгүй байна.....	7
Аймаг, нийслэлийн аудитын газрууд	Хүн амын унд, ахуйн хэрэглээний усны чанар хангалтгүй байна.....	10
2011 оны 12 дугаар сар	Бүлэг 2 Усны нөөцийн ашиглалт зохистой бус, усны төлбөр төлөлт хангалтгүй байна	
Уг тайланг ҮАГ-ын Вэб сайтаас үзнэ үү	Хүн амын ус ашиглалтыг сайжруулж, зохисгүй хэрэглээг бууруулж чадахгүй байна.....	12
<u>www.mnao.mn</u>	Усыг цэнгэгжүүлэх, зөөлрүүлэх тоног төхөөрөмжүүд шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.....	13
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 263533, 323266 дугаарын факсаар харилцана уу.	Хүн амын унд, ахуйн хэрэглээний болон үйлдвэрлэлийн бохир усыг бүрэн цэвэршүүлж чадахгүй байна.....	13
Хаяг:	Хөдөө аж ахуйн салбарын ус ашиглалт, хамгаалалтын арга хэмжээ үр дүн муутай байна.....	14
Үндэсний аудитын газар	Уул уурхай, үйлдвэрлэлд хаягдал усыг ашиглах бодлого үгүйлэгдэж байна.....	15
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын IV байр	Ус, рашаан ашигласны төлбөрийн орлого нэмэгдэж байгаа ч усны төлбөр бүрэн төлөгдөхгүй байна.....	17
Улаанбаатар хот 15160	Усны газар улсын төсөвт төвлөрүүлэх ёстой орлогыг өөрийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.....	19
Монгол улс	Бүлэг 3 Усны талаарх эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй байна	
	Усны тухай хууль эрхийн актууд хууль зүйн ба эдийн засгийн хөшүүргийн үүргээ гүйцэтгэж чадахгүй байна.....	20
	Бүлэг 4 Усны асуудал хариуцсан төрийн байгуулагуудын нэгдсэн бүтэц, удирдлага,	

	зохион байгуулалт оновчгүй, ажлын уялдаа холбоо хангалтгүй байна	
	Усны харилцаанд олон байгууллага оролцож байгаа ч нэгдсэн зохицуулалт алга	22
	Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ, ЗД, БОАЖГ, МХГ-ууд бүрэн эрхээ хэрэгжүүлэхгүй байна.....	25
	Сав газрын зөвлөлүүд бүрэн эрхээ хэрэгжүүлэн ажиллаж чадахгүй байна.....	26
	Дүгнэлт.....	28
	Зөвлөмж.....	29
	Холбогдох байгууллагын санал	31
	Хавсралт.....	33
	Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаал	38

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
ЗТБХБЯ	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ЭБЭХЯ	Эрдэс баялаг, эрчим хүчний яам
ГХБГЗЗГ	Газрын харилцаа, барилга, геодези зураг зүйн газар
СХЗГ	Стандарт хэмжил зүйн газар
ЦУОШГ	Цаг уур, орчны шинжилгээний газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХХААЖДҮГ	Хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийн газар
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
УУХ	Усны үндэсний хороо
УСУГ	Ус сувгийн удирдах газар
СГЗ	Сав газрын зөвлөл
УЦБ	Урьдчилан цэвэрлэх байгууламж
ТЦБ	Төв цэвэрлэх байгууламж
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ДБХС	Дэлхийн байгаль хамгаалах сан
УННМ	Усны нөөцийн нэгдсэн менежмент
НАГ	Нийслэлийн аудитын газар
НЗД	Нийслэлийн Засаг дарга
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ерөнхий газар
БГД	Баянгол дүүрэг
ХУД	Хан-Уул дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
НЭМХ	Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл

Аудитыг Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны санал, Монгол Улсын Ерөнхий аудиторт 2011 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон УАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Монгол орны усны нөөцийн хамгаалалт, ашиглалтын байдлыг шалган дүгнэлт, зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Усны асуудал хариуцсан төрийн байгууллагуудын бүтэц зохион байгуулалт, түүний чиг үүрэг, хэрэгжилт
- Усны нөөцийн хамгаалалт, ашиглалтын талаар явуулж буй бодлого, хэрэгжилт үр нөлөөтэй эсэх

Хамарсан хүрээ

Аудитаар БОАЖЯ, ЗТБХБЯ, ЭМЯ, ЭБЭХЯ, ХХААХҮЯ-ны холбогдох газар, хэлтэс, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар, Газрын харилцаа, барилга, геодези зураг зүйн газар, Усны нөөцийн нэгдсэн менежментийн төсөл, аймаг, нийслэлийн БОАЖГ, ХХААЖДҮГ, Ус сувгийн удирдах газар болон холбогдох бусад байгууллагуудын усны нөөцийн хамгаалалт, ашиглалт, хэрэгжилтийн талаархи 2010, 2011 оны тайлан, судалгаа, мэдээлэл бусад баримт материалыг хамруулан шалгав.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитын дараах арга зүйг ашиглав. Үүнд:

- Аудитад хамрагдсан байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, лавлагаа, тодруулга авах, судлах;
- Цуглуулсан мэдээ судалгаанд дүн шинжилгээ, харьцуулалт хийх;
- Усны салбарын мэргэжлийн болон төрийн бус байгууллагын холбогдох мэргэжилтэнтэй ярилцлага хийж, холбогдох мэдээ, судалгаа гаргуулах;
- Усны дээж авч эрх бүхий байгууллагуудаар лабораторийн шинжилгээ хийлгэж, мэргэжлийн дүгнэлт гаргуулж үнэлэх, зураг авалт хийх;
- Усны асуудал эрхэлж байгаа төрийн байгууллагуудын бүтэц зохион байгуулалт, чиг үүрэгтэй танилцаж үнэлэлт дүгнэлт гаргах;
- БОАЖЯ, Усны газрын гаргасан заавар, журмын боловсруулалт, хэрэгжилтийн байдал, ажлын тайлагнал, усны салбарын мэдээ судалгааг авч үзэв.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитыг УАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар, Аймаг, нийслэлийн аудитын газрын аудитор, шинжээчид хамтран гүйцэтгэв. Аудит хийхэд НЭМХ-ийн Эрүүл ахуй, хүний экологийн төвийн захирал, Академич Н.Сайжаа, Геологийн, МХЕГ-ын магадлан итгэмжлэгдсэн, Цөмийн энергийн нэгдсэн лабораторийн ажилтнуудын мэргэжлийн туслалцааг авсан болно.

Бүлэг 1

Монгол орны гадаргын болон газрын доорхи усны нөөцийг бүрэн тогтоогоогүй байна.

1.1. Монгол орны гадаргын усны нөөцийн 70 хувь Алтай, Хангай, Хэнтийн нуруу, Хөвсгөлийн уулс, Их Хянганы нуруу зэрэг уул нуруудын өндөрлөг хэсэгт, нийт нутаг дэвсгэрийн 30 орчим хувийг эзлэн оршдог бөгөөд Хойд мөсөн далай, Номхон далай, Төв Азийн гадагш урсгалгүй ай савуудад багтах 17 томоохон гол, мөрөн, тэдгээрийн цутгалуудыг тэжээж, ихэнх голууд нийлэн хөрш орнууд руу урсан гардаг онцлогтой.


Усны нөөцийг бүрэн тогтоогоогүй байна

1.2. Монгол Улс усны нөөц багавтар орнуудын тоонд ордог бөгөөд эх газрын эрс тэс уур амьсгалтай, байгалийн бүс бүслүүрийн онцлогоос хамааран усны нөөц нь жигд бус тархсан, тэжээмж багатай, ууршилт ихтэй орон юм. Тухайлбал, гадаргын усны тархацаар нь авч үзвэл 599 шоо км нөөцийн 380 шоо км буюу 63.4 хувь нь зөвхөн Хөвсгөл нуурт агуулагдаж байна.

1.3. ЗХУ-ын (хуучин нэрээр) мэргэжилтнүүдийн тусламжтайгаар 1971-1975 онд монгол орны нийт усны нөөцийг 608,29 шоо км гэж тогтоосон бөгөөд үүнээс гол мөрөн 34,6 шоо км, нуур тойром 500,0 шоо км, мөнх цас, мөсөн гол 62,9 шоо км, газрын доорх ус 10,79 шоо км гэж тогтоожээ. Усны нийт нөөцөөс ашиглаж болох боломжит нөөц нь 15,75 шоо км бөгөөд үүнээс 4,96 шоо км нь гадаргын ус, үлдсэн нь газрын доорх ус байна.

1.4. Үүнээс хойш усны нөөцийг дахин тогтоогоогүй бөгөөд энэ хугацаанд дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, дулаарал, уул уурхайн үйлдвэрлэл, хүн амын усны хэрэглээний өсөлт, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн зүй бус ашиглалт зэргээс шалтгаалан усны нөөц өөрчлөгдсөн байх магадлал их юм.

1.5. Монгол орны усны нөөцийн 90 гаруй хувь нь байгалийн эргэлтийн нөлөөгөөр түргэн нөхөгдөн сэргэдэг гадаргын ус эзэлж байна. Усны нийт нөөцийн 1.96 хувийг газрын доорх ус эзэлдэг бөгөөд энэ нөөцөөс төв суурин газрын усны хэрэглээний 80-90 хувийг хангаж байна.




1.6. Усны газар 2005-2011 онд 31 ордод газрын доорх усны нөөцийг тогтоож, усны салбарын мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, БОАЖС-ын тушаалаар батлуулсан боловч энэ нь улс орныг бүхэлд нь хамарч чадаагүй.

1.7. Иймд Монгол орны усны нөөцийг өнөөгийн байдлаар бодитой тогтоох нь усны талаар баримтлах төрийн бодлогыг оновчтой тодорхойлж хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Усны тооллого хийж байгаа боловч дүн шинжилгээ хийгдэхгүй байна

1.8. Усны тухай хуулийн 8.1-ийг үндэслэн “Улсын усны тоо бүртгэл явуулах тухай” БОАЖС-ын 2011 оны А-124 дүгээр тушаалаар тоо бүртгэл явуулах комисс, салбар комиссын бүрэлдэхүүнийг томилж 2011 оны 5 дугаар сарын 15-аас 7 дугаар сарын 20 хүртэлх хугацаанд улсын хэмжээнд 54 групп, 1586 хүн ажиллуулж, 293.0 сая төгрөг зарцуулж, энэхүү тооллогыг зохион байгуулсан байна.

2003, 2007, 2011 оны тоо бүртгэлийн дүнг харьцуулсан байдал



1.9. Усны тооллогын 2011 оны дүнг өмнөх жилүүдтэй харьцуулахад гол, горхи булаг шандын тоо хэмжээ өсч, ширгэсэн тоо хэмжээ буурчээ. Харин ширгэсэн нуур тойрмын тоо буурч, устай нь өссөн дүн гарчээ.

1.10. Усны хуулийн дагуу тооллогыг 2003, 2007, 2011 онд хийсэн бөгөөд зөвхөн тоологдсон, устай болон ширгэсэн тоо төдийхнөөр дүн мэдээ гаргаад орхиж байгаа нь учир дутагдалтай байна. Тоо мэдээнд дүн шинжилгээ хийх, ширгэсэн усны шалтгааныг тодорхойлох, ширгээгүй усны нөөц, түвшинг баримжаалах, түүнд үндэслэн авах арга хэмжээг тодорхойлохгүй байгаа нь усны тооллого хийхийн ач холбогдол, зарцуулсан санхүүгийн болон хүний нөөцийн үр ашгийг бууруулж байна.

Хүн амын унд, ахуйн хэрэглээний ус хангамжийн нөөцийг зүй зохистой тогтоож чадахгүй байна

1.11. Манай улсын томоохон хотуудын хүн амын ихэнх нь цэвэр, бохир усны төвлөрсөн сүлжээнд холбогдсон бол аймгийн төвүүд, орон нутгийн хотуудын нийтийн орон сууцанд оршин суугчид зөвхөн хүйтэн цэвэр ус болон бохирын сүлжээнд холбогдсон, бусад нь ус зөөвөрлөн түгээдэг хөдөлгөөнт цэг болон ус түгээх зориулалттай худгаас унд, ахуйн зориулалттай усаа авч байна.

1.12. Хүн амын усан хангамжийн зориулалтаар улсын төсөв болон хувийн хөрөнгөөр 2008-2011 онд газрын доорх усны эрэл, хайгуулын 14 ажил хийгдэж, Улаанбаатар

хотын Хан-Уул дүүрэг, 8 аймагт нөөцийг тогтоож, БОАЖС-аар баталгаажуулжээ. (Хавсралт 1)

1.13. Зарим аймгийн удирдлага ундны усны нөөцийг шинэчлэн тогтоох ажил зохион байгуулаагүй, Усны тухай хуулийн 14.1.3¹-д заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхгүй байна. Тухайлбал, Баянхонгор, Хөвсгөл, Булган, Баян-Өлгий, Өвөрхангай, Дорноговь зэрэг аймгууд усны нөөцөө тогтоосноос хойш 25 жил өнгөрсөн байна.

1.14. 1980 оны Монгол, Зөвлөлтийн ашигт малтмалын нөөцийн комиссын хамтарсан хуралдаанаар Улаанбаатар хотын ундны усны нөөцийг 4 эх үүсвэрээс нийт 215900 м³/хоног гэж баталгаажуулсан бөгөөд “ГИПРОКОМУН ВОДКАНАЛ” институт 175 худгаас 248000 м³/хоногийн нөөцтэй гэж тодотгожээ.

1.15. Монгол Улс болон Япон Улсын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны хүрээнд ЖАЙКА-ийн судалгааны баг Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөнд 2008 онд хийсэн судалгаагаар Улаанбаатар хотын цэвэр усны хэрэглээг 2 хувилбараар тооцсон байна. Үүнд: Өндөр хувилбараар тооцвол 2020 онд 351300 м³/хоног, 2030 он гэхэд 510700 м³/хоног болох ба бага хувилбараар тооцвол 2020 онд 294900 м³/хоног, 2030 онд 367700 м³/хоног болно гээд одоогийн хүчин чадал болох 241000 м³/хоног усны хэрэглээ нь 2012 онд эрэлтийн хэмжээ нөөцтэй тэнцэж, 2015 онд усны хомсдолд орж болзошгүй гэсэн дүгнэлт хийжээ.

1.16. ЗХУ-ын экспедиц дээд эх үүсвэрийн ашиглалтын нөөцийг 89700 м³/хоног гэж тогтоосон боловч нөөцийн комиссоор оруулж баталгаажуулалгүй ашиглаж ирсэн ба нөөц тогтоох хугацаа 25 жил гэж үзэхэд шинээр ашиглалтын нөөцийг тогтоох зайлшгүй шаардлага гарч байна.

1.17. Ус бол өдөр тутмын зайлшгүй чухал хэрэгцээ учраас усгүй бол улс орон хөгжих нь байтугай, оршин тогтнох ч боломжгүй юм. Өнөөдөр дэлхийн улс орнууд валют болон төсвийн орлогоо нэмэгдүүлэхээс илүү усны нөөцийг нэмэгдүүлэх асуудлыг төрийн бодлогоор шийдвэрлэх чиглэлийг барьж байна.

Усны нөөцийг хамгаалалтад авч байгаа ч түүний дэглэмийг мөрдөхгүй байна

1.18. 2010 онд усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг тогтоох ажлыг Усны газар, орон нутгийн Засаг дарга нар, Байгаль орчныг хамгаалах иргэний зөвлөл (ТББ)-тэй хамтран зохион байгуулж, 3335 талбайн 28337 газарзүйн эргэлтийн цэгийн солбицлыг тогтоож, мэдээллийн бааз үүсгэн аймаг тус бүрээр газарзүйн зураг боловсруулжээ. (Хавсралт 2)

1.19. Засгийн газрын 2011 оны 174 дүгээр тогтоолоор “Алтны шороон ордын тусгай зөвшөөрөл олгогдсон талбайн хэсэгт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хэсэгчлэн тогтоосон хилийн зааг”-ийг баталсан байна. Уг хилийн заагт хамрагдсан алтны шороон ордын ашиглалтын 233 тусгай зөвшөөрлийг хуулийн дагуу хүчингүй болгосноос усны хамгаалалтын бүсэд 92, урсац бүрэлдэх эхийн талбайд 17, бүгд 119 нь устай холбогдон цуцлагдсан байна.

1.20. Орон нутагт уст цэгийн хамгаалалтын бүсийг тогтоож байгаа ч тэмдэгжүүлэлт тэр бүр хийгээгүй, хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдөж ажиллаагүй байна.

¹ улсын зэрэглэлтэй хотын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн эрэл, хайгуул, судалгааны захиалга гаргаж, байгаль орчны болон барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад оруулах

Тухайлбал, Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Өвөрхангай, Говь-Алтай, зэрэг 11 аймаг, Улаанбаатарт хамгаалалтын бүсийн дэглэм зөрчигдөж байна.

1.21. Улаанбаатар хотын төвлөрсөн ус хангамжийн тэжээгдлийн мужид хамгаалалтын бүс тогтоох тухай НЗД-ын 2003 оны 30, 2009 оны 95 дугаар захирамжууд, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12.8.2-т “Хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсэд орон сууц, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламж барихыг хориглоно” гэж заасныг зөрчиж газар олгосоор байна.

1.22. Хамгаалалтын бүсийн дэглэм, Газрын тухай хуулийн 6.2-т “Хуульд өөрөөр заагаагүй бол дараах газрыг төрийн зохих шатны байгууллагын хяналт, зохицуулалттайгаар нийтээр ашиглана” гэж заасныг зөрчиж байгууллагуудад газар олгож, эзэмшүүлжээ. Тухайлбал, НЗД-ын 2007 оны 163 дугаар захирамжаар ШШГЕГ-ийн эзэмшилд 6 га газрыг, БГД-ийн Засаг даргын 2006 оны 362 дугаар захирамжаар хур хогийг цэвэрлэж 83 иргэн, аж ахуйн нэгжид газар олгожээ.

Ундны усны тэжээгдлийн дотоод мужид газар олгосон байдал:

“ЭДМ” ХХК-ийн усны хамгаалалтын 397 дугаар тэмдэгтийн өмнө талд барилгын суурь тавьж байгаа байдал



1.23. НЗД-ын 2007 оны 436 дугаар захирамжаар БГД-ын Засаг даргын 462 дугаар захирамжийг хүчингүй болгосон ч, тус газрын эзэмшигч нар Захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргаж Захиргааны хэргийн шүүхийн 2009 оны 180 дугаар шийдвэрээр НЗД-ын дээрх захирамжийг хүчингүй болгож цөөхөн хэдэн хүний эрх ашгийн үүднээс ундны усны эх үүсвэрт суурьшлийн бүс бий болгожээ.

1.24. 2009-2011 онд усны хамгаалалтын бүсэд зөвшөөрөл олгосон байдал

№	Байгууллагын нэр	Туул голын ай савд	Захирамжийн огноо дугаар
1	Аураг мандал ХХК	БГД 20-р хороо	НЗД-ын 2010.12.8-ны 821 тоот
2	Мөрөөдлийн орчин ТББ	БГД 20-р хороо	НЗД-ын 2010.01.25-ны 63 тоот
3	Монголын хот байгуулалтын хүрээлэн	ХУД 4-р хороо	НЗД-ын 2009.04.24 -ны 165 тоот
4	Космо прожект ХХК	ХУД 3 хороо	НЗД-ын 2009 оны 275 тоот
5	Тэмүүлэн –од ХХК	БЗД 11 хороо	ЗД-ын 2009 оны 299 тоот
6	“Нэйшнл инженеринг” группийн urban developer ХХК	БГД 20-р хороо	БГД-ын ЗД-ын 2011.05.30-ны өдрийн 254 тоот

1.25. Нийслэл, дүүргийн Засаг дарга нар Газрын тухай хуулийн 33.4² дэх заалтыг зөрчиж эрхээ хэтрүүлэн дээрх ААНБ-д газар эзэмшүүлжээ. Энэ нь 2009 онд

² “Аймаг, нийслэл, сум дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд эзэмшүүлж болохоор зааснаас бусад газарт газар эзэмшүүлэхийг хориглоно.”

хамгаалалтын дотоод муж тогтоож, тэмдэгжүүлсэн цэнхэр шонгоос дотогш байгаа бөгөөд БГД-ийн нутаг дэвсгэрт л гэхэд тус муж дотор 11 объектод газар олгосон байна.

1.26. НЗД-ын 2009 оны 95 дугаар захирамжийн хавсралт зургийг “нууц” хэмээн бидэнд өгөөгүй бөгөөд уг зургийг Усны газар, УСУГ, БГД-ийн газрын алба зэрэг байгууллагаас авахад хоорондоо зөрж байна.

1.27. Энэ нь газар олголтыг эмх замбараагүй байдалд хүргэх, ундны усны эх үүсвэр болон хот төлөвлөлт, усны бодлогод сөргөөр нөлөөлж болохыг анхаарах шаардлагатай байна.

1.28. Усны тухай хууль, усны нөөцийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийг чанд мөрдөх, чөлөөлөлт хийгдсэн газруудыг хамгаалж, хашлага хийх, усны хэрэглээний асуудлыг хот төлөвлөлтийн бодлоготой уялдуулан зохион байгуулах, холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг нээлттэй болгох шаардлагатай байна.

1.29. Улаанбаатар хотын ус хангамжийн төвлөрсөн системийн усны эх үүсвэрийн дотоод мужид хууль, журам зөрчин олгосон газар эзэмших эрхийг нийслэлийн Засаг даргын 2010 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 403 дугаар захирамжаар хүчингүй болгожээ.

1.30. Гэвч захирамжийн хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал, зарим аж ахуйн нэгж, иргэний газар эзэмшлийн объект ундны усны тэжээгдлийн дотоод мужид байрласан хэвээр байна. Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын нэр	Тэмдэглэгээ тэй баганын дугаар	НЗД-ын Захирамжаар батлагдсан Усны тэжээлийн дотоод мужийн хамгаалалтын бүсийн цэгийн байршлын солбицлууд			Хэмжилтээр иргэн, аж ахуйн нэгж байгууллага дээр тогтоогдсон цэгийн солбицолын дүн		
		h	N	E	h	N	E
Агнитрейд ХХК-ийн хашаа	402	1291м	47°53'18.86	106°55'57.6	1262м	47°53'19.1	106°48'29.9
Хар усан тохойн амралтын газар	318	1327м	47°55'03.4	107°06'55.6	1326м	47°54'43.3	107°07'26.7
Хувийн орон сууцууд	317	1340 м	47°55'29.7	107°08'25.5	1330 м	47°54'43.3	107°07'26.7
МоносфармХХК Эмийн үйлдвэрийн агуулахын байр	398	1267м	47°53'16.4	106°47'35.7	1268м	47°53'10.9	106°07'18.3
Молор контрактн ХХК-ийн Тавилгын үйлдвэр	380	1284 м	47°53'16.4	106°50'30.8	1260 м	47°53'10.2	106°46'47.5
WHITEMOOD.construction Барилга угсралтын засвар үйлчилгээний газар	380	1284 м	47°53'16.4	106°50'30.8	1260 м	47°53'10.2	106°46'47.5
"Green city" ХХК хүнсний нарийн ногооны хүлэмжийн газар	319	1325 м	47°54'55.61	107°05'45.55	1320м	47°54'53.20	107°03'15.87

1.31. Ундны усны тэжээгдлийн дотоод мужийн баганы тэмдэглэгээний өндөр 34 см байгаа нь алсаас хүний нүдэнд харагдахгүй, мужийн хилийг тогтоосон тэмдэглэгээ болж чадахгүй байна.

Гачуурт тосгон дахь Монгол шилтгээн ХХК, ДЦС 4-ийн урд талд байгаа ундны усны тэжээгдлийн дотоод мужийн баганы тэмдэглэгээ



1.32. Зарим шатахуун түгээгүүрийн станц үерийн далан дээр болон далангийн эрэг орчимд байгаа нь ундны ус шатахуун, шатах тослох материалаар бохирдох эрсдэл үүсгэж байна.

Үерийн далан дээр байгуулагдсан шатахуун түгээх байгууламж



1.33. Хотжилтын нөлөөгөөр нийслэлийн голуудын ойролцоох газар доорх ус хураах талбай бохирдох нөхцөл бүрдэж байгаа тул газар доорх усны эх үүсвэрийг хамгаалах ариун цэвэр, эрүүл ахуйн хязгаарлалтын болон тэжээгдлийн дотоод бүс тогтоож, гидрогеологийн технологи, эрүүл ахуйн оновчтой шийдэл сонгож, хуульчлах шаардлагатай байна.

Хүн амын унд, ахуйн хэрэглээний усны чанар хангалтгүй байна

1.34. Усны газар усны тоо бүртгэлийн явцад хүн амын ундны усны нийт 446 эх үүсвэрээс дээж авч шинжилгээ хийжээ. Шинжилгээнд хамрагдсан 11 аймгийн 94 сумын ундны усны ерөнхий химийн үзүүлэлт нь хэвийн хэмжээнээс их, 6 аймгийн 54 сумынх хэвийн хэмжээнээс бага үзүүлэлттэй гарсан нь цаашид сумдын усны эх үүсвэрийн чанарыг сайжруулах, зөөлрүүлж, цэнгэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

1.35. Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн, Хүний экологийн төвтэй хамтран Туул голын дагуу 10 цэгээс 15 дээж, хотын усан хангамжийн дээд, А, Б, В станцуудын эх үүсвэрээс нян судлалын 4 дээж, ус түгээгүүрийн дотоод сүлжээний крантны уснаас радиоизотопын идэвх тодорхойлох 3 дээж тус тус авч лабораторийн шинжилгээ хийв.

1.36. Хотын усан хангамжийн дээд, А, Б, В станцуудын эх үүсвэр болон Тэрэлж орчим, Налайхын бохир нийлэхийн өмнөх Туул голын усны эрдэсжилт 126,6 - 313,5 мг/л, хатуулаг 1,4- 2.10 мг/ экв, усны орчин (pH) 6.5-7.2 өнгөгүй, тунгалагжилт 30 см, анион катионын агууламж стандартад заасан хэмжээнээс бага байгаа нь цэвэр, нэн цэнгэг усны ангилалд багтаж байна.

1.37. Харин Туул голын Налайхын бохир ус нийлэх хэсэгт аммони $/\text{NH}_4^+ /$ 5.98 мг/л, Сонгины амралтын ойролцоо Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн бохир ус Туул голд нийлж байгаа хэсэгт Аммони $/\text{NH}_4^+ /$ 5,03 мг/л хэмжээтэй буюу гадаргын усны стандарт MNS 4586:98-д заасан аммоны ионы хэмжээнээс их байгаа нь цэвэрлэгдсэн бохир усанд байх органик нэгдлийн бохирдолт их байгааг илтгэж байна.

1.38. Налайх болон Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламжууд бохир усыг технологийн дагуу, стандартын шаардлага хангахуйц хэмжээнд цэвэрлэхгүй нийлүүлж байгаагаас Туул голын усны өөрөө цэвэрших гидробиологи, гидрологийн дэглэм алдагдаж, голын усанд органик, микробиологийн бохирдолт ихэсчээ.

1.39. Мөн Улаанбаатар хотын унд ахуйн төвлөрсөн усан хангамжийн газрын доорх усны тэжээгдлийн муж Туул голоос бохирдох эрсдэл өндөр байгаа бөгөөд үүний улмаас хүн амын дунд элдэв халдварт өвчин голомтлон, дэгдэлт хэлбэрээр гарч болзошгүй байна.

1.40. Усанд агуулагдах кальци, магнийн хэмжээ бага байгаа нь хүн амыг зарим эрдэс бодисын дутагдалд орох, мөн усанд фторын агууламж 0.1 мг/л буюу стандартад заасан хэмжээнээс 0.7-1.5 дахин бага байгаа нь хүүхдийн шүд цоорох өвчнийг нэмэгдүүлэхэд нөлөөлөх магадлалтай байна.

1.41. Төв цэвэрлэх байгууламжаас гарч буй цэвэрлэгдсэн бохир ус Туул голтой нийлж буй цэгээс эхлэн (Сонгины гүүрээс доош Төв аймгийн Алтанбулаг сум өнгөртөл) Туул-Овоотын гүүр хүртэл эвгүй үнэртэй, Сонгины гүүрийн орчим ус маш бохир, хар ногоон өнгөтэй замаг бий болсон нь гол дагуух малтай айл өрх, хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, улмаар нийслэлийн хүн амд худалдаалагдаж буй мах, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний чанар, аюулгүйн баталгаа алдагдах нөхцөл үүсгэж байна.

1.42. НБОГ-ын 2010 оны судалгаагаар нийслэл хотод 1614 гаруй хувийн хэрэглээний худаг байна. Эдгээрийн дийлэнх нь усыг шинжлүүлээгүй, эрүүл ахуйн бүсийн дэглэм мөрдөөгүй байна. Энэ нь ХСУХАТТ хуулийн 12.12. *"Иргэн хувийн хэрэгцээндээ зориулж гаргасан усны эх үүсвэрээс бусад хэрэглэгчийг усаар хангах нөхцөлд хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөнө"* гэсэн заалтыг зөрчиж байна.

1.43. Гэр хорооллын ус түгээх байрны орчин бохирдолтой, иргэд өөрсдийн гаргасан худгаас шинжлүүлээгүй ус хэрэглэсэн зэргээс өвчин үүсэх, эрүүл орчны дэглэм алдагдах магадлалтай учраас дээрх худгуудыг шинжилгээнд бүрэн хамруулж, эрүүл ахуйн дэглэмийг мөрдүүлэх шаардлагатай байна.

Бүлэг 2

Усны нөөцийн ашиглалт зохистой бус, усны төлбөр төлөлт хангалтгүй байна.

2.1. Өнөөгийн байдлаар улсын хэмжээнд ус ашиглалт, хэрэглээнд тавих хяналт боловсронгуй бус, хууль эрх зүйн орчин, мэдээллийн тогтолцоо бүрдээгүй байгаагаас ус ашиглалт, хэрэглээний талаарх мэдээллийг нарийвчлан гаргах боломжгүй ч тойм судалгаа хийснийг дараах хүснэгтээр харуулав.³

№	Ус ашиглагч салбарууд	Нийт ус ашиглалт сая шоо метр
1	Хүн амын унд ахуйн ус	71.5
2	Мал аж ахуй	113,0
	Хөдөө аж ахуй	Усалгаатай газар тариалан 129
3	Үйлдвэр	Боловсруулах үйлдвэрүүд 35.8
		Уул уурхай олборлох үйлдвэрүүд 93.8
		Эрчим хүч дулааны цахилгаан станц 27.6
		Усан цахилгаан станц 80.0
4	Аялал жуулчлал	1.68
5	Ногоон байгууламж	0.27
	Нийт	552.65



2.2. Дээрх хүснэгтээс харахад манай улс өнөөгийн байдлаар жилд 552,65 сая, өдөрт 1,5 сая орчим шоо метр ус хэрэглэж, ашиглаж байгаагийн 42,9 хувийг үйлдвэрлэлийн салбарт буюу боловсруулах, уул уурхайн олборлох үйлдвэр, эрчим хүч, дулааны цахилгаан станцад, 12,9 хувийг хүн амын ундны хэрэгцээнд ашиглаж байна.

Хүн амын ус ашиглалтыг сайжруулж, зохисгүй хэрэглээг бууруулж чадахгүй байна

2.3. Хот суурин газрын нийт хүн амын 23 орчим, түүний дотроос Улаанбаатарын хүн амын 40 гаруй хувь нь төвлөрсөн усан хангамжийн системээс, 8.5 хувь нь шугамд холбогдсон ус түгээх байрнаас, 8.6 хувь нь хамгаалагдсан худагнаас, 0.1 хувь нь хамгаалалттай булгаас ундны усаа авч хэрэглэж байна. Ус хангамжийн сайжруулсан байгууламжийн хүртээмж улсын хэмжээнд 40.2 хувь байгаа нь дэлхийн дунджаас 20 гаруй хувиар доогуур төвшинд байна⁴.

2.4. Хөдөөгийн хүн ам, мал аж ахуйг усаар хангах зориулалтаар 2011 оны байдлаар 36 мянга гаруй худаг хөдөө ашиглагдаж байгаагийн 25 мянга орчим буюу 68 хувь нь гар худаг, 12 мянга орчим нь инженерийн хийцтэй худаг байна. Нийт малчин өрхийн ус хэрэглээ 2,5 сая.м³ орчим бөгөөд хөдөөгийн зарим малчин өрх өдөрт 8 литр хүрэхгүй ус хэрэглэж байна.

2.5. Хүн амын төвлөрөл ихтэй Улаанбаатар хотын гэр хорооллын нэг оршин суугч дунджаар 5-7 литр цэвэр ус хоногт хэрэглэж байна.



³ "Монгол орны усны нийт ашиглалтын байдал", Д.Доржсүрэн, 2011

⁴ "Ότο πόοόεϊ άάσδύϊ όñ δαϊάαϊάε, άδέοόάάδ δαόόόδάύϊ °ñ°ϊ ίύϊύάύδ δύδύάδύύ", α.Όύάύϊάάϊάα, 2011

2.6. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх, улсын хэмжээнд усны нөөцийг хэмнэх, усны алдагдлыг бууруулах, үйлчилгээ, айл өрхөд нэвтрүүлэх, тоолууржуулалтын ажлыг эрчимжүүлэх, түүнийг зохицуулах зорилгоор Усны газраас “Усны ашиглалт хэрэглээг тоолууржуулах журам”-ын төслийг боловсруулсан хэдий ч хуульд заагдаагүй гэсэн шалтгаанаар батлагдаагүй байна.

2.7. Орон сууцны айл өрхийг тоолууржуулснаар зохисгүй хэрэглээ багасах юм. ОСНААУГ-ын 2011 оны 3 дугаар улирлын мэдээгээр нийт 1269 орон сууцны 76174 хэрэглэгчийн 43.7%, 5292 аж ахуйн нэгжийн 91.4%-ийг тоолууржуулсан байна.

2.8. Орон нутгийн хэрэглэгчдийг бүрэн тоолууржуулж чадахгүй байна.

- Хөвсгөл аймгийн УСНААК ХХК ОНӨҮГ төвлөрсөн шугам сүлжээгээр нийт 133 аж ахуйн нэгж, байгууллагыг усаар хангаж байгаагаас 37 ус хэрэглэгчийн 5 нь, 95 ус ашиглагч байгууллагын 27 нь тоолууртай байна.
- Баянхонгор аймагт нийт 1011 хэрэглэгчээс (айл өрхийн тоо 900, албан газар 111) 71 хэрэглэгчийг тоолууржуулсан байна.
- Төв аймгийн төвийн төвлөрсөн усан хангамжид холбогдсон нийт 69 аж ахуйн нэгж байгууллагуудаас 62 буюу 89.9 хувийг тоолууржуулсан, 1312 айл өрхийн 90 айл буюу 6.8 хувь нь тоолууртай байна.
- Архангай аймгийн төвийн төвлөрсөн усан хангамжид холбогдсон ус ашиглагч 75 аж ахуй нэгжийн 57.7 хувь нь тоолуур тавиулсан байна.

Усыг цэнгэгжүүлэх, зөөлрүүлэх тоног төхөөрөмжүүд шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна

2.9. Өнөөгийн байдлаар улсын хэмжээгээр 107 сумын хэрэглэж байгаа уст цэгийн усыг цэнгэгжүүлэх, чанаржуулах асуудал шийдвэрлэгдээгүй байна.

2.10. Энэ асуудлын хүрээнд зарим аймгуудад цэнгэгжүүлэх, зөөлрүүлэх тоног төхөөрөмжийг төсвийн болон гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлдэг боловч түүнд тавих хяналт хангалтгүй байна.

- Баянхонгор аймгийн 14 сумдын төвийн гүн өрмийн худгуудад ус цэнгэгжүүлэх төхөөрөмж суурилуулсан хэдий ч өвөл төхөөрөмжүүд хөлдөж бүрэн ажиллаагүй;
- Дорноговь аймагт ус цэнгэгжүүлэх зөөлрүүлэх 17 тоног төхөөрөмжөөс 7 нь эвдэрч ашиглагдахгүй болсон;
- Хөвсгөл аймгийн 5 сумын худагт ус зөөлрүүлэх, цэвэршүүлэх төхөөрөмжийг суурилуулсан ч 2 нь усаа бүрэн цэвэршүүлж чадахгүй;
- Өвөрхангай аймгийн 8 сумын ундны усны хатуулаг, эрдэсжилтийг зөөлрүүлэх тоног төхөөрөмжүүдийг суурилуулсан ч ажиллахаа болиод 2 жил болсон;
- Дундговь аймгийн 6 суманд Чех улсын болон Тогтвортой амьжиргаа төслийн хөрөнгөөр ус зөөлрүүлэх төхөөрөмжийг суурилуулснаас 2 сумын цэвэршүүлэх төхөөрөмжийн шүүлтүүр хөлдсөний улмаас цэвэршүүлэлт хийхгүй байна.

Хүн амын унд ахуйн хэрэглээний болон үйлдвэрлэлийн бохир усыг бүрэн цэвэршүүлж чадахгүй байна

2.11. Аймаг, нийслэлийн хот, суурингийн төвлөрсөн усан хангамж, бохир ус зайлуулах үүргийг тусгай зөвшөөрөл бүхий орон нутгийн өмчит үйлдвэрийн газар болон ХХК-иуд хэрэгжүүлдэг боловч бүрэн цэвэрлэж чадахгүй байна.

2.12. УЦБ “Хархираа” НӨҮГ-аас 2010 онд цэвэрлэсэн усанд УСУГ-ын усны лаборатори сар бүр шинжилгээ хийж байгаа бөгөөд усанд байх ёстой химийн

үзүүлэлт зөвшөөрөгдөх хэмжээнээс 0.26-4.84 дахин их гарсан нь арьс ширний үйлдвэрүүдээс нийлүүлж буй бохир уснаас болжээ.

2.13. ТЦБ нь ахуйн бохир ус цэвэрлэх зориулалтаар баригдсан учир үйлдвэрийн бохирдлыг бүрэн цэвэрлэдэггүй, лабораторийн шинжилгээний дундаж дүнгээр, механик цэвэрлэгээ 48.73%, биологийн цэвэрлэгээ 72.30%-тай байгаа нь 95%-аас багагүй байх ёстой гэсэн стандартын шаардлагыг хангахгүй байна.

2.14. ТЦБ-ын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Туул голын бохирдлыг бууруулах, Туул-21, Испани улсын засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр тоног төхөөрөмж сайжруулах төсөл тус тус хэрэгжсэн ч бохир усыг бүрэн цэвэрлэх техникийн нөхцөл бүрдээгүй байна. УСУГ стандартын шаардлага хангаагүй бохир ус нийлүүлж байгаа иргэн ААН-ийг усаар хангахгүй байх үүргээ хэрэгжүүлээгүй байна.

2.15. “Усны экологи, эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолын хавсралтад тусгасан Туул голын сав газрын гадаргын усны бохирдлын үнэлгээгээр зөвхөн шинжилгээнд хамрагдсан дээрх үйлдвэрүүдийн 2010 онд нийлүүлсэн **512099** м³ бохир усанд **1.3 тэрбум** төгрөгийн төлбөр ногдохоор байна. Гэвч энэ төлбөрийг бохир ус нийлүүлсэн үйлдвэрүүдээс авч эхлээгүй байна.

2.16. Орон нутагт цэвэрлэх байгууламжууд бүрэн ажиллахгүй байна.

- Дархан-Уул аймгийн “Дархан-Ус суваг” ХК-ийн цэвэрлэх байгууламж гадаадын төслөөр станцын болон лабораторийн техник, тоног төхөөрөмж, зарим машин механизмыг шинэчлэх ажил хийгдэхээр гэрээ хийж, цэвэрлэх байгууламжийн цэвэршүүлэлт 88-94 хувьд хүрсэн ч үйлдвэрийн бүсийн бохир ус дамжуулан шахах станцын хүчин чадал муугаас үйлдвэрлэлийн бохирдлыг бүрэн татан зайлуулж чадахгүй байна.
- Хөвсгөл аймгийн Мөрөн сумын цэвэрлэх байгууламж 2001 онд Герман улсын хөрөнгө оруулалтаар баригдсан, бохир усыг байгалийн аргаар хөрсөнд шингээдэг нягтруулсан шороон байгууламж бөгөөд 2006 оноос энэ байгууламжийн хүчин чадал нь хүрэлцэхгүй болсон, өвлийн улиралд бохир нь хальж орчныг бохирдуулж байна.
- Булган аймгийн цэвэрлэх байгууламж 1987 онд анх ашиглалтад орж, 2009 онд АХБ-ны буцалтгүй тусламжаар их засвар хийгдсэн боловч тус байгууламж бохир усыг тунгаагуураар дамжуулж шүүж цэвэршүүлэлгүй татан зайлуулах станц хэлбэрээр ажиллаж лагийн талбайг битүүмжлээгүй, ил задгай бохир усыг асгаж байна.
- Өвөрхангай аймгийн Хужирт суманд үйл ажиллагаа явуулдаг “Хужирт” рашаан сувилал бохир усаа ойролцоогоор 150-200 метрийн зайд байрлах хонхорт нуур үүсгээд шингэн хэсгийг хоолойгоор гадагш урсгахад 2 км яваад Халуун усны голд нийлжээ.

Хөдөө аж ахуйн салбарын ус ашиглалт, хамгаалалтын арга хэмжээ үр дүн муутай байна

2.17. 2008-2011 онд 215 усалтын системийг шинээр барих буюу сэргээн засварлаж ашиглалтад оруулснаар усалгаатай тариалан, хадлангийн талбайн хэмжээ 33,235,3 га-аар нэмэгдэж, 2011 оны эцсийн байдлаар 46,5 мянган га талбайд усалгаатай тариалан эрхэлж байна.

2.18. Хөдөөгийн хүн ам, мал аж ахуйн усан хангамжийг сайжруулах зориулалтаар худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах, худгийн барилга барих ажилд MNS6088:2010 стандартыг мөрдөж ажиллахгүй, худгийн байршлыг оновчтой тогтоогоогүй зэрэг зөрчил гарч байна. Тухайлбал,

- 2.19. Усны тухай хуулийн 12.2.12⁵ дугаар зүйлд заасны дагуу Усны газрын дүгнэлт гараагүй байхад услалтын системүүдийг шинэчлэх, сэргээн засварлах шийдвэрийг ХХААХҮЯ гаргасан байна. Тухайлбал,

Уул уурхай, үйлдвэрлэлд хаягдал усыг ашиглах бодлого үгүйлэгдэж байна

2.21. Одоогоор манай оронд хаягдал усыг дахин ашиглах технологи бүрэн нэвтрээгүй байгаа бөгөөд дэд бүтэц, үйлдвэрлэл, уул уурхайн салбарт хаягдал усыг эргүүлэн ашиглах, цэвэршүүлэх, зөөлрүүлэх, цэвэр усыг хэмнэлттэй ашиглах арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2.23. Ахуйн болон үйлдвэрлэлийн ус хэрэглээний зааг, ялгааг тогтоох, үйлдвэрлэл, барилга байгууламжийн хэрэглээний усны шугамыг ундны цэвэр усны шугамаас салгах, хаягдал усыг цэвэршүүлж эргүүлэн ашиглах бодлого, арга хэмжээ дутагдалтай байна.

2.25. Зарим стратегийн ордуудыг ашиглах, үйлдвэрийн парк байгуулж, ажиллуулахад шаардагдах усны хэрэгцээг өмнийн говийн бүс нутгийн усан хангамжийн гол эх үүсвэрүүдийн нөөцтэй нь харьцуулан үзвэл:

- [illegible]

яваандаа үйлдвэрлэлийн ашиглалтаас хасагдаж болзошгүй байна.

- Сайншанд-Замын-Үүдийн бүс нутгийн ус хэрэглээ ойрын 20 орчим жилд **554 мянган м³хоног**, газрын доорх усны тогтоогдсон нөөц **409 мянган м³хоног** байгаа нь **145 мянган м³хоногийн** хомсдол үүснэ. ⁶

2.26. Өмнийн говь бүсийн стратегийн орд газруудаас олборлосон ашигт малтмалыг усны нөөц сайтай хангайн бүсэд боловсруулах боломжийг “Ус үндэсний хөтөлбөр” дэх “Орхон-говь”, “Хэрлэн-Говь” төслүүдтэй харьцуулан судлах нь зүйтэй.

ШУА, Геоэкологийн хүрээлэн, Усны нөөц, ус ашиглалтын салбарын эрхлэгч, доктор Л.Жанчивдоржийн тайлбарт Оюу толгойн уулын үйлдвэрийн Гүний хоолойд Aquaterra Co Лсс-ийн хийсэн судалгааг тэжээлийн нөхцлийг тооцоогүй ерөнхий, регионал шинжтэй болсон тул үйлдвэрлэлийн үйл ажиллагааг төлөвлөх нь эрсдэлтэй, 3 жилийн хугацаанд ашиглах явцад хөндлөнгийн байгууллагаар усны нөөц, түвшин бууралт, усны чанарын өөрчлөлтөд хяналт хийлгэн улмаар байгальд ээлтэй ашиглах зөвлөмжөөр дахин тооцоо хийх нь зүйтэй гэж үзжээ.

2.27. Уул уурхайн олборлох болон боловсруулах үйлдвэрүүдэд ашиглагдаж байгаа усны хэрэглээг хэмнэх, бохирдлыг багасгах, тоолууржуулах, паспорттай болгох, хаягдал усыг дахин ашиглах ажил хангалтгүй байна.

- Баянхонгор аймагт гүний худаг ашиглаж байгаа уул уурхайн компаниуд яндан хоолойгоор дамжуулан ашиглаж байгаа боловч “Бадамлах Очир” ХХК гүн өрмийн худгийн усыг шуудуу татан задгай урсган нуур үүсгэн ашиглаж байна.
- Дорноговь аймагт аудитад хамрагдсан ихэнх ААНБ-ууд ус ашиглуулах дүгнэлт гаргуулаагүй, зөвшөөрөл аваагүй, гэрээ байгуулаагүй, эрхийн бичиг олгогдоогүй, тоолуур тавилгүйгээр ус ашиглаж, ус ашигласны төлбөрөө цаг хугацаанд нь бүрэн төлөөгүй, “Си Өү Эй Эл” ХХК уурхайн үйлдвэрлэлд Өлзийтийн энгийн худаг, Цагаан цавын гүний зэрэг зөвшөөрөлгүй гаргасан 3 худгаас усыг их хэмжээгээр ашиглаж байна. Эдгээр худгууд холбогдох газрын дүгнэлтгүй, орон нутгаас зөвшөөрөл аваагүй, гэрээ байгуулаагүй бөгөөд сумын байгаль орчны мэргэжилтэнтэй тохиролцож усны төлбөрийг төлж байна.
- Мөн Эрдэнэ сумын нутагт өрөмдлөг хайгуулын ажил хийж байгаа “Коммод” ХХК ус ашиглах дүгнэлт гаргуулаагүй, орон нутгаас зөвшөөрөл аваагүй ус ашиглалтын цооног гаргасан.
- Архангай аймгийн Цэнхэр сумын Орхон багийн нутаг дэвсгэрт “Монгол газар” ХХК, “Алтан дорнод Монгол” ХХК-ууд уул уурхайн үйлдвэрлэл эрхлэх уулын ажлын болон байгаль хамгаалах төлөвлөгөөгүй атал өөрсдийн талбайнуудад нөхөн сэргээлт хийлгэх нэрээр бусад компаниудтай хууль бус гэрээ байгуулснаас эфель дахин угаах уулын ажил явагдаж гол усыг ихээр бохирдуулсан байна.

2.28. “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай УИХ-ын 2009 оны 55 дугаар тогтоолын дагуу ашигт малтмал ашиглаж байсан аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авсан ч заримынх нь лицензийг цуцлаагүй байна. Тухайлбал:

- Төв аймагт алтны шороон ордын зөвхөн 56 тусгай зөвшөөрлийн ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газартай давхацсан хилийн зааг тогтоогдсон Туул голын усны хомсдол, бохирдолд ихээхэн сөрөг нөлөө үзүүлж буй Алтанбулаг сумын нутагт голын ай сав газарт олгогдсон хайрга, дайраг, элс олборлох, хайх 38 тусгай зөвшөөрлийн талбайн усны

⁶ l'ááýýëëèéí yō ¿¿ñâyðèéã óníú ãaçðàañ àààâ

энгийн хамгаалалтын бүстэй давхацсан хэсгийг одоо болтол шийдээгүй байна.

- Баянхонгор аймагт уул уурхайн хайгуул, ашиглалт явуулж буй 23 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг цуцлуулахаар дэд шатны холбогдох байгууллагад санал хүргүүлсэн боловч одоогоор шийдэгдээгүй байна.

Ус, рашаан ашигласны төлбөрийн орлого нэмэгдэж байгаа ч усны төлбөр бүрэн төлөгдөхгүй байна.

2.29. Татварын ерөнхий газрын мэдээгээр улсын хэмжээнд ус, рашаан ашигласны төлбөр 2008 онд 2,8 тэрбум, 2009 онд 3,0 тэрбум, 2010 онд 4,7 тэрбум төгрөг болж жил бүр өсөн нэмэгдэж байгаа ч гэсэн усны төлбөрийн хэмжээ аймаг бүрт харилцан адилгүй байна.

Түхайлбал,

- Баян-Өлгий аймгийн татварын хэлтэст усны төлбөр төлөгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн талаар бүртгэл, судалгаа байхгүйн зэрэгцээ 2008-2010 онд 1091,3-1839,7 мянган төгрөг буюу жилд дунджаар 1531,5 мянган төгрөг,
- Орхон аймаг 1876,7-2161,2 мянган төгрөг буюу жилд дунджаар 1923,5 мянган төгрөгийн усны төлбөр төлж байгаа нь хамгийн бага үзүүлэлт юм.
- Сонгино хайрхан дүүрэг 909,4-1650,8 мянган төгрөг, Хан-Уул дүүрэг 2796,8-7179,8 мянган төгрөгийн ус, рашааны төлбөр төлсөн бол Баянзүрх, Сүхбаатар, Баянгол, Чингэлтэй, Багахангай дүүргийн татварын хэлтэст аж ахуйн нэгж, байгууллагаас ус, рашааны төлбөр төлсөн гэх баримт алга байна.

2.30. Өнөөдөр манай оронд усны үнэ харьцангуй хямд байгаа нь усыг арвилан хэмнэх, эргүүлэн ашиглах сэтгэлгээг бий болгохгүй байна.

2.31. УСУГ-ын үйл ажиллагааны тайлангаас үзэхэд орон сууц ашиглалтын байгууллагад түгээх цэвэр усны үйлчилгээний төлбөр нэг шоо метрт 281 төгрөг, бохир үс татан зайлуулах үйлчилгээний үнэ нэг шоо метрт 162 төгрөг байна.

2.32. Гэтэл Засгийн газрын 2009 оны 351 дүгээр тогтоолын хавсралтаар уул уурхайн үйлдвэрлэлд ашигласан усны үнэ нэг шоо метр тутамд 100-150 төгрөг, хөрсний усыг шавхан зайлуулах үнэ 50 төгрөг байгаа нь ус ашигласны төлбөрийн үнэ тарифыг эргэн харах шаардлагатайг харуулж байна.

2.33. Усны экологийн үнэлэмж болох ус бохирдуулсны төлбөр, усны нөөцөд учруулсан хохирлын үнэ, ус рашаан ашигласны болон бохир ус цэвэрлэсний төлбөр зах зээлийн зарчимд шилжиж чадаагүй байна.

Бусад орны усны борлуултын үнийг харьцуулбал⁷

- **АНУ-ын** Ориган мужид амьдардаг 3 ам бүл хоногт дунджаар 400 галлон буюу 1500 л ус хэрэглэж сард **34\$ буюу 48 000** төгрөг төлж байна.
- **Токиод** амьдардаг 3 ам бүл хоногт 200 иен сард 6000 иен ойролцоогоор **60000 орчим төгрөг** төлдөг
- **Монголд** 3 ам бүл сард усны төлбөрт **2100** төгрөг төлсөн байна.
- **Германд** хоногт нэг хүн манайх шиг 340 л биш 200 л ус хэрэглэдэг гэвэл 3 ам бүлтэй айл сард **54.2 \$ буюу 70 000 мянган** төгрөг төлж байна.

2.34. Тэгвэл манайх Америкаас **23 дахин**, Японоос **28 дахин**, Германаас **33 дахин** бага мөнгө төлж байна. Дээрх орнууд манайхыг бодоход усаар баян орнууд билээ.

⁷ Óníû ãàçďûí ìyăýyěyě

2.35. Усны тухай хуулийн 8.3, 21.1, 23.1, 26.1, 26.3, 30.1, Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг болон “Ус ашигласны төлбөрийн хувь, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2009 оны 351 дүгээр тогтоолын дагуу ус ашигласны төлбөрийг төлөөгүй аж ахуйн нэгж, байгууллагууд байсаар байна.

2.36. Тухайлбал, 2010 оны байдлаар ДЦС-II 2076 384 м³ ус ашигласны 62,3 сая төгрөг, ДЦС-III 9364'400 м³ ус ашигласны 280,9 сая төгрөг, ДЦС-IV 410'259'600 м³ ус ашигласны 307,7 сая төгрөг, бүгд 21'700'384 м³ буюу 651,0 сая төгрөгийн ус ашигласны төлбөрийг төлөөгүй байна.

2.37. Аймаг, нийслэлийн Аудитын газрууд ус ашигласны төлбөрийг төлүүлэхээр 150,9 сая төгрөгийн акт, ус, рашаан ашигласны төлбөрийн орлогын 35 хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй, булаг, шандны эхийг хамгаалах ажлыг дутуу гүйцэтгэсэн зөрчлийг арилгуулахаар 386,6 сая төгрөгийн албан шаардлага өгсөн байна. (хавсралт 3)

2.38. Усны салбарын эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна. Тухайлбал, татварын ерөнхий хуулийн 7.4.5-т “Ус, рашааны нөөц ашигласны төлбөр, татвар орон нутгийн татварт хамаарна” гэж заасан боловч уг татвар бүрэн төвлөрөхгүй байна.

2.39. “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай” хуулийн 4.1.5-д ус рашаан ашигласны төлбөрийн орлогын 35 хувийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар хуульчилсан. Гэтэл орон нутгийн төсөвт бүрэн төвлөрөхгүй, төвлөрсөн төлбөрөөс 35 хувийг хуулийн дагуу зарцуулахгүй байна.

2.40. Орхон аймгийн ИТХТХ-ын 2006 оны 12-р сарын 27-ны 19 дугаар тэмдэглэлд “Газрын төлбөрийн тухай 7 дугаар тогтоолоор тогтоосон итгэлцүүрийг баримтлан тооцсон үнийн зөрүүгээр энэ жил үүссэн усны үнийн зөрүүг суутган тооцоо хийж дуусах” гэсэн шийдвэрийг үндэслэн Эрдэнэт үйлдвэртэй Газар ашигласны төлбөрийн гэрээ байгуулж, хотын хэрэглээний усны үнийн зөрүүг газрын төлбөрөөс 2 012,8 сая төгрөгөөр суутган тооцсон байна.

2.41. Гэвч энэ нь тухайн ондоо л хэрэгжих шийдвэр байсан бөгөөд түүнээс хойш 2008, 2009, 2010 оны “Газар ашигласны төлбөрийн гэрээ”-нд 2012,8 сая төгрөгийн газрын төлбөрийг хотын хөдөлмөрчдийг унд, ахуйн усаар хангагч Эрдэнэт-Ус ОНӨХК, Эрдэнэт-Амьдрал ХХК-иудтай холбоотой усны төлбөрийн зөрүүд тооцож байна гэж тусгаж, Эрдэнэт үйлдвэрийн газар ашигласны төлбөрийн орлогоос усны төлбөрийг хасч тооцож иржээ.

2.42. УСУГ нь орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар бөгөөд газрын гүн дэх усны нөөцөөс 2009 онд 52,8 сая м³, 2010 онд 52,1 сая м³, 2011 оны эхний 10 сарын байдлаар 45,8 сая м³ усыг олзворлон орон сууцны конторуудад (1 м³ нь 250.91 төгрөг, бохир ус 147 төгрөгөөр) болон үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагуудад (цэвэр ус 550-1000 төгрөг, бохир ус 300-2000 төгрөгөөр) худалдан борлуулж, 2010 онд 20,7 тэрбум төгрөг, 2011 оны 3 дугаар улирлын байдлаар 17,7 тэрбум төгрөгийн орлого олсон байна.

2.43. УСУГ орон сууцны контор болон үйлдвэр аж ахуйн нэгж, байгууллагаас усны төлбөрийг нэхэмжлэн авахдаа усны үнэ болон үйлчилгээний төлбөрт Засгийн газрын 2009 оны 351 дүгээр тогтоолоор баталсан тарифыг үндэслэн газрын доорх ус ашигласан төлбөрийг нэмж тооцож, өөрийн дансанд нэхэмжлэн авсны дараа нийслэлийн төсвийн орлогод төвлөрүүлж байна. Өөрөөр хэлбэл тус газар Нийслэлийн татварын газрын ажлыг гүйцэтгэж, өөрөө ус ашигласны төлбөр төлөхгүй байна.

2.44. УСУГ-тай ижил үйл ажиллагаа эрхэлж буй, аймгийн төвийг усаар хангадаг орон нутгийн өмчит компаниуд ус ашиглах дүгнэлт гаргуулж, ус ашиглалтын тайлан мэдээгээ улсын усны мэдээллийн санд жил бүр тайлагнаж, төлбөрөө төлж байна.

Усны газар улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг өөрийн үйл ажиллагаандаа ашиглаж байна

2.45. Усны газар 2009-2010 онд усны дүгнэлт гаргасан үйлчилгээний болон зураг төслийн мэргэжлийн дүгнэлтийн хураамжид бүгд 165,2 сая төгрөгийг Татварын ерөнхий хууль, Нэгдсэн төсвийн тухай хуулийн заалтыг зөрчиж, улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэлгүй өөрийн үйл ажиллагаанд ашиглаж байна.

(мянган төгрөг)

Он	Усны нөөц ашигласны төлбөр	Усны дүгнэлт гаргасан үйлчилгээний хураамж	Зураг төслийн мэргэжлийн дүгнэлтийн хураамж	Орлогын дүн	Улсын төсөвт төвлөрүүлсэн	Усны газарт үлдсэн
2009	112 657.0	66 466.4	2341.2	181 464.6	153 834.1	27 630.5
2010	453 257.1	79 090.5	1 090. 0	533 437.6	328 598.0	204 839.6
2011.10.01	32 224.4	20 401.8		52 626.2	119 914.2	(67 288.0)
Дүн	598 138.5	165 958.7	3431.2	767 528.4	602 346.3	165 182,1

2.46. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12.1-т агентлагийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ гэж заасны дагуу Усны газар улсын төсвөөс санхүүжих бөгөөд төлбөр хураамж, үйлчилгээний хөлс зэрэг орлогыг төсөвт төвлөрүүлэх ёстой.

2.47. Нэгдсэн төсвийн тухай хуулийн 6.2-т “Энэ хуулийн 21.1.2-21.1.30 дахь заалтад заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг энэ хуульд заасан хязгаарт багтаан Засгийн газар тогтооно” гэсэн атал Усны газрын даргын 2011 оны А/23 дугаар тушаалаар ус ашиглуулах дүгнэлт гаргах заавар, түүний үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоожээ.

2.48. Усны газарт байрлаж буй Усны судалгаа хөгжлийн хүрээлэн төрийн өмчийн байр ашигласны төлбөрийг төлөөгүй зөрчлийг арилгуулах зөвлөмж өгөв.

Бүлэг 3

Усны талаарх эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй байна.

Усны тухай хууль эрхийн актууд хууль зүйн ба эдийн засгийн хөшүүргийн үүргээ гүйцэтгэж чадахгүй байна

3.1. Усны талаарх харилцааг дараахь хуулиудаар зохицуулж байна.

- Усны тухай хууль (2004 он)
- Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль (2002 он)
- Рашааны тухай хууль (2003 он)
- Ус рашаан ашигласны төлбөрийн тухай хууль (1995 он)

3.2. Усны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа бөгөөд энэ нь зохицуулалт хийх гол механизмууд хуульд бүрэн тусгагдаагүйтэй холбоотой байна. Тухайлбал,

- Усны нөөц, усны сав газар, усны сан бүхий газар, усны экологи-эдийн засгийн үнэлгээ, ус ашиглагч, ус бохирдуулагч, усны аудитын тухай зэрэг ойлголтууд одоо мөрдөгдөж буй хуульд бүрхэг эсхүл огт тусгагдаагүй,
- Бохирдуулагч нь төлөх, ашиглагч нь хамгаалах зарчмыг баримтлах шаардлагатай болсон,
- Усны сав газрын зөвлөлийн статус тодорхой бус, санхүүжилтийн эх үүсвэр нь хуульчлагдаагүйгээс улсын хэмжээнд байгуулагдаад байгаа 14 гол мөрний сав газрын зөвлөлүүд үр дүнтэй үйл ажиллагаа гүйцэтгэж чадахгүй байгаа,
- Хууль тогтоомжийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын талаарх хуулийн заалтууд өнөөгийн нөхцөлд нийцэхгүй болсон. Тухайлбал Усны тухай хуулийн 37.1.8-д “усыг бохирдохоос хамгаалах шаардлагыг биелүүлээгүй, эсхүл усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн иргэнийг 20’000, аж ахуйн нэгж байгууллагыг 50’000-200’000 хүртэл төгрөгөөр торгох” гэж заасан нь өнөөгийн нөхцөлд хэт бага бөгөөд хууль хэрэгжүүлэх хөшүүргийн шинж чанараа алдсанаас, зөрчлийн тоо нэмэгдсэн. Мөн хуульд үйл ажиллагааг зогсоох, татан буулгах гэх мэт торгуулиас өөр арга хэмжээг тусгаагүй,
- Усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах асуудал бүрэн зохицуулагдаагүй,
- Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутгийн захиргааны усны талаарх хариуцлага, эрх үүргийг хуульчлан заагаагүй,
- Усны харилцаанд оролцогч төрийн захиргааны төв байгууллагуудын эрх үүрэг тодорхойгүй, ажлын уялдаа холбоо сул, чиг үүрэг давхардах буюу эзэнгүйдсэн байна. Усны тухай хуулийн 7 дугаар зүйлд усны мэдээллийн сан ба кадастртай байхаар, мөн хуулийн 12.2.9-д усны асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий байгууллага мэдээллийн санг хөтөлж байхаар заасан боловч мэдээлэл цуглуулах механизм тусгагдаагүй учир төрийн байгууллагууд мэдээллээ солилцдоггүй, нэгдсэн мэдээллийн сан өнөө хүртэл бүрдээгүй байна,
- Ус бага хэрэглэх техник, технологийг нэвтрүүлснийг урамшуулах механизм тодорхойгүйгээс байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд ус гамнах, бага хэрэглэх сэтгэлгээ төлөвшихгүй байна.

Иймд Усны тухай хуулийг шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.

3.3. Усны харилцааг зохицуулах гол хууль болох “Усны тухай” хуулийг шинэчлэн батлуулсны дараа түүнд нийцүүлэн бусад хуулиудыг өөрчлөх буюу шинээр

боловсруулах шаардлага байна. Ингэж чадвал уул уурхай, зам тээвэр, үйлдвэр зэрэг олон салбарын усны төлөө өрсөлдөөн ихсэж, усны хомсдол нүүрлэж буй өнөөгийн нөхцөлд усны менежментийг ус хангамж, нийгмийн эрүүл мэндийн үр өгөөж, усны чанартай холбосон багц хуультай болох юм.

3.4. Өөрөөр хэлбэл, “Усны чанарын хяналтын тухай”, “Усны нөөцийг хамгаалах тухай”, “Үйлдвэрлэлийн усны тухай”, “Бохир усны тухай”, “Усны бохирдлоос сэргийлэх тухай”, “Ус бохирдуулсны төлбөрийн тухай” гэх мэт бие даасан хуулиудыг Усны тухай хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн батлуулж, багц хуулийг хэрэгжүүлэх дүрэм, журам, стандартыг мөрдүүлэхгүй бол усны салбарын болон усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдэхээргүй байна.

3.5. Усны тухай ерөнхий хууль шинэчлэгдэхээс өмнө салбар хуулиуд батлагдах нь зөрчил үүсгэж байна. Тухайлбал, Хот суурин газрын ус суваг ариутгах татуургын тухай хууль 2011 оны 10 сарын 6-ны өдөр шинэчлэн батлагджээ. Ингэснээр Усны тухай хуультай давхардал, зөрчил үүсгэж байна.

- Усны тухай хуульд ус “хэрэглэгч” болон “ашиглагч”-ийн нэр томъёо тусгагдсан боловч “хангагч” байгууллагын талаар дурдаагүй. Гэтэл Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд “хангагч” байгууллага гэсэн нэр томъёо орсон нь усны тухай хуульд заасан хэрэглэгч, ашиглагчийн алинд хамаарах нь тодорхойгүй болжээ.
- “Ус хэрэглэгч” гэж цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйлчилгээгээр үйлчлүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийг” заасан нь усны тухай хуультай давхардаж байгаа бөгөөд “ус ашиглагч” гэдгийг тодорхойлоогүй,
- Ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсэд Усны тухай хуулийн 34.1-д зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно: Үүнд, “17.8.1 газрын тосны бүтээгдэхүүн, химийн бодис болон цацраг идэвхит бодис хадгалах” гэж заасан боловч уг асуудал Усны тухай хуулийн 34.1-д тусгагдсан,
- “Үйлчилгээний тарифын хэмжээг тогтоох саналыг боловсруулж Зохицуулах зөвлөлөөр батлуулж, мөрдөх нь хангагчийн үүрэг” гэж 14.2.6 –д заасан нь Усны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д заасан усны барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигчтэй зөвшилцсөний үндсэн дээр усны үйлчилгээний хөлсийг Сум, дүүргийн ИТХ-ын бүрэн эрхэд хамаарна гэсэн заалттай зөрчилдөж байна.

Бүлэг 4

Усны асуудал хариуцсан төрийн байгууллагуудын нэгдсэн бүтэц, удирдлага, зохион байгуулалт оновчгүй, ажлын уялдаа холбоо хангалтгүй байна

Усны харилцаанд олон байгууллага оролцож байгаа ч нэгдсэн зохицуулалт алга байна.

4.1. Байгаль экологийн тэнцвэрт байдлыг хангах үүднээс Засгийн газрын тухай⁸ хууль, Усны тухай хуулийн 10.1.1⁹-д Засгийн газрын бүрэн эрхийг тусгасан бөгөөд усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх усны менежментийн харилцаан дахь төрийн захиргааны төв байгууллагуудын чиг үүргийг тодорхойлжээ.

Тухайлбал:

Яам	БОАЖЯ	ЭМЯ	ЗТБХБЯ	ХХААХҮЯ	ЭБЭХЯ	БСШУЯ
Чиг үүрэг	Байгаль орчныг хамгаалах зохистой ашиглах, нөхөн сэргээх болон экологийн бодлого; Усны нөөцийг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах асуудал	Хүн амын эрүүл мэндийг хамгаалах нийгмийн болон мэргэжлийн арга хэмжээ Нөхөн сэргээх бодлого	Далай ашиглах болон усан замын тээврийн асуудал; Барилга , барилгын материалын үйлдвэрлэлийн бодлого; Хот байгуулалт, архитектурын асуудал; Орон сууцны бодлогын асуудал; Нийтийн аж ахуйн асуудал; Газар зохион байгуулалтын бодлого, геодези, зураг зүйн асуудал	Хөнгөн үйлдвэрлэлийн бодлогын асуудал; Хүн амын хүнсний хангамжийн бодлого Мал аж ахуй болон газар тариаланг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого	Эрчим хүчний нэгдсэн бодлого Сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх асуудал Бүс нутгийн түлш, эрчим хүчний асуудал Эрдэс баялгийн бодлого	Боловсролын тогтол цоог хөгжүүлэх асуудал; Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын асуудал;

4.2. Усны нөөц, түүнийг нэмэгдүүлэх, хамгаалах асуудлыг БОАЖЯ, усан замын тээвэр, хот суурингийн хүн амын усны хэрэгцээ, газар зохион байгуулалтын асуудлыг ЗТБХБЯ, хөдөө аж ахуйн болон хүнс, хөнгөн үйлдвэрийн усны хэрэгцээг ХХААХҮЯ, уул уурхайн болон эрчим хүчний үйлдвэрүүдийн усны хэрэгцээ, усны эрчим хүчийг ЭБЭХЯ, хүн амын ундны усны чанар, хүн амын эрүүл мэндийг нөхөн сэргээх асуудлыг ЭМЯ, усны салбарын боловсон хүчнийг бэлтгэх, шинжлэх ухааны судалгаа, технологийн бодлогыг БСШУЯ хариуцаж байна.

4.3. БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газар “... ус, хөрсний бохирдол, доройтол, сөрөг нөлөөллийг бууруулах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагааг төлөвшүүлэн хэрэгжүүлэх үндсэн үүрэг хүлээж, ...ой, ус, ургамал, амьтан болон бусад байгалийн баялгийг ашиглах, хамгаалах арга хэмжээг зохион байгуулах, зохицуулах” чиг үүрэгтэй бөгөөд энэ асуудлыг 1 мэргэжилтэн хариуцан ажиллаж байна.


4.4. БОАЖЯ болон УҮХ, харъяа агентлагуудад усны 35 мэргэжилтэн ажиллаж байна.

⁸ Газар, түүний хэвлий, ус, ойн сан, агаар мандал, ургамал, амьтны аймгийг хамгаалах, зүй зохистой ашиглах төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна”

⁹ усны талаархи төрийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулж, хангах”

№	Байгууллагын нэр	Албан тушаал	Мэргэжилтний тоо
1	БОАЖЯ	Усны бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн	1
		Усны бодлого төлөвлөлтийн асуудлыг хариуцсан шинжээч	1
2	УУХ	Дарга, нарийн бичгийн дарга, гишүүд	2
3	ЦУОШГ	Эрдэм шинжилгээний ажилтан	5
		Инженер техникийн ажилтан	6
		Лаборант	2
4	Усны газар	Мэргэжлийн хэлтсийн ажилтнууд	18
	Дүн		35

4.5. Усны газар нь газрын доорх усны нөөц, түүний ашиглалт, хамгаалалтын байдалд дүгнэлт гаргах, усны талаарх нэгдсэн болон салбар дундын бодлогыг тодорхойлох, усны талаарх хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүрэгтэй ажиллаж байна. Бүтцийг схемээр харуулбал:



4.6. Усны газар нь удирдлага, санхүүгийн, усны нөөцийн, ус ашиглалтын, кадастр, хяналт шинжилгээний гэсэн 4 хэлтэстэй бөгөөд батлагдсан орон тоо 31 боловч 35 ажилтан ажиллаж байна. Үүний дотор үндсэн ажилтан 23, гэрээт ажилтан 12 ажиллахын зэрэгцээ мэргэжлийн 3 хэлтэст 18 хүн, удирдлага болон удирдлага санхүүгийн хэлтэст 17 хүн байна.

4.7. Усны асуудал эрхэлсэн Засгийн газрын агентлаг байгуулагдаад 7 жил гаруй болж байхад усны нөөцийг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх менежментийн төлөвлөгөө боловсруулах ажил хийгдэж дуусаагүй байна.

4.8. 1971-1976 онд тогтоосон усны нөөцийн тоо, хэмжээг одоо хүртэл ашиглаж байгаа бөгөөд нөөцийг шинэчлэн тогтоож чадаагүй, усны нөөцийн өөрчлөлт, чанарын хяналт хийх мониторингийн нэгдсэн сүлжээ алга байна.

4.9. БОАЖЯ, Усны газар, аймаг, нийслэлийн БОАЖГ-т хяналт, шалгалт хийдэг боловч улсын байцаагчийн эрхгүй учир илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь засаж залруулах, хууль бус үйл ажиллагааг нь зогсоох зэрэг арга хэмжээ авч чаддаггүй, хяналт шалгалтын ажил үр дүнгүй байна.

4.10. Усны харилцаанд оролцож буй бусад яамдын мэргэжилтэн, тэдгээрийн хариуцаж буй ажлыг харуулбал:

№	Байгууллагын нэр	Хариуцсан ажил	Тоо
1	ЗТБХБЯ-ны • Барилга орон сууц нийтийн аж ахуйн бодлогын газар • ЗГХА ГХГДЗЗГ-ын Орон сууц нийтийн аж ахуйн хэлтэс	Ус, дулаан хангамжийн инженерийн байгуулалт	1
		Сум, суурингийн ус хангамж ариутгах татуургын асуудал	1
		Хот суурингийн усан хангамж ариутгах татуургын ашиглалт	2
2	ХХААХҮЯ-ны • МАА бодлогын хэрэгжитийг зохицуулах газар • Газар тариалангийн бодлогын хэрэгжитийг зохицуулах газар	Бэлчээр усжуулалт	1
		Худаг уст цэгийн ашиглалт	1
		Газар тариалангийн усалгаажуулалт	1
		Усалгаатай тариалангийн тоног төхөөрмж барилга байгууламж	1
3	ЭБЭХЯ	Усны асуудал хариуцсан бүтэц чиг үүрэг байхгүй	
4	БСШУЯ-ны ШУА харъяа Геоэологийн хүрээлэн	Усны нөөц, ус ашиглалтын судалгааны эрдэмтэд	4
5	ЭМЯ-ийн • Эмнэлгийн тусламжийн хэрэгжилтийг зохицуулах газар • НЭМХ	Рашаан сувилал хариуцсан	1
		Хүн амын унд ахуйн хэрэглээний усан хангамж ил задгай усан сангийн бохирдол, эх булгийн ариун цэврийн хамгаалалт, эрүүл ахуйн шаардлага, уснаас шалтгаант өвчин эмгэгээс сэргийлэх чиглэлийн эрдэмтэд	7
	Бүгд		16

4.11. Дээрх хүснэгтээс харахад ЭБЭХЯ-наас бусад яам, агентлагт усны бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий бүтэц байгаа боловч, салбар хоорондын ажлын уялдаа холбоогүй, бодлого төдийлөн оновчтой бус, тус тусдаа ажиллаж байна

4.12. Япон улсын туршлагаас үзэхэд усны нөөц, хамгаалалт, ашиглалтын асуудал газрын харилцаа дэд бүтцийн хөгжлийн яам, Хүрээлэн буй орчны яам зэрэг 5 яамны эрхлэх ажлын хүрээнд хамаарч байгаа бөгөөд усны асуудлаарх салбар дундын зохицуулалтыг Салбар хоорондын төрийн бус зөвлөл эрхлэн гүйцэтгэж байна.

4.13. Манай улсын хувьд төрийн захиргааны 6 яам, тэдгээрийн харъяа агентлагууд усны нөөц, түүний хамгаалалт, ашиглалтын асуудлыг хариуцаж байгаа бөгөөд салбар хоорондын зохицуулалт хийх бүтэц нь Усны үндэсний хорооны дүрэмд заасны дагуу БОАЖС-ын эрхлэх асуудлын хүрээнд байгаа бөгөөд БОАЖСайд өөртэйгээ адил эрхтэй бусад сайд нарт үүрэг чиглэл өгөх эрхгүй байна.

4.14. Усны үндэсний хороо нь БОАЖЯ, БХЯ, ХХААХҮЯ, СЯ, ХЗДХЯ, ЭБЭХЯ, ЭМЯ-ны ТНБД нар, МХЕГ-ын газрын дарга, Усны газрын дарга нарын бүрэлдэхүүнтэй ажиллаж, жилд нэг л удаа хуралдаж байна. Гэвч хуралдаанд яамдын ТНБД нар өөрсдөө оролцдоггүй тэднийг төлөөлж тухайн яамдын мэргэжилтнүүд оролцож байгаа нь шийдвэр гаргах түвшнийг хангаж чадахгүй байна.

4.15. Энэ бүхнээс үзэхэд усны харилцаанд төрийн захиргааны олон байгууллага оролцож байгаа боловч Усны бодлогыг хэрэгжүүлэх, удирдан чиглүүлэх салбар дундын оновчтой бүтэц үгүйлэгдэж байна.

4.16. Усны үндэсний хороог Ерөнхий сайд буюу эсвэл шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамааруулан бүрэлдэхүүнийг нь усны салбарын холбогдох ажилтнуудаас гадна эрдэмтэн, судлаач, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан өргөжүүлж, салбар дундын зохицуулагчийн эрхтэй болгох нь зүйтэй байна.

Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ, ЗД, БОАЖГ, МХГ-ууд бүрэн эрхээ хэрэгжүүлэхгүй байна.

4.17. Усны болон Рашааны тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ ус, рашааны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, усны хөнөөлөөс урьдчилан сэргийлэх талаар СГЗ, Засаг даргаас оруулсан дүгнэлт хөтөлбөр, түүнд шаардагдах төсөв хөрөнгийг хэлэлцэж батлах, гаргасан шийдвэрийн биелэлтийг хянаж дүгнэх эрхтэй ч тэр бүр хэрэгжүүлдэггүй байна.

4.18. Тухайлбал, Архангай, Өвөрхангай, Орхон, Хэнтий, Дорнод аймгууд ИТХ-аар батлагдсан усны хөтөлбөртэй бол бусад аймгуудад буюу 77 хувьд нь ийм хөтөлбөр алга байна.

4.19. Нийслэл, Төв, Ховд, Хөвсгөл, Баян-Өлгий аймгуудаас бусад нь гаргасан шийдвэрийнхээ хэрэгжилтийг огт хянадаггүй байна.

4.20. Аймаг, нийслэлийн захиргааны байгууллагуудад байгаа усны мэргэжлийн боловсон хүчний судалгаа хийж үзэхэд ЗДТГ-ын хөгжлийн бодлогын хэлтэст 3, байгаль орчин аялал жуулчлалын газарт 8, мэргэжлийн хяналтын газарт 4 мэргэжилтэн тус тус ажиллаж байна. Сумдад усны мэргэжлийн хүн байхгүй байна. (Хавсралт 4)

4.21. Нутаг дэвсгэртээ рашааныг зохистой ашиглах, чанарыг хамгаалах талаар арга хэмжээ төлөвлөөгүйгээс Рашааны тухай хуулийн 9.1.2¹⁰, 9.1.3.¹¹, Усны тухай хуулийн 34.1¹² дүгээр заалтуудыг зөрчин барилга байгууламж барих зөвшөөрөл олгосноор рашааны орд бохирдох, хомсдох, халдварт өвчин тархаж болзошгүй байна.

4.22. Орон нутгийн БОАЖГ усны тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж, холбогдох албан тушаалтанд зөвлөмж өгөх, сумдын Засаг дарга, БОХУБ-д албан бичиг хүргүүлэх зэрэг ажлыг зохион байгуулж, тайлангаа аймаг, нийслэлийн ИТХ, Засаг даргаар хэлэлцүүлэн, БОАЖЯ, Усны газарт мэдээ хүргүүлж байна.

4.23. Байгаль орчны тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд тавих хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлж байгаа бөгөөд МХЕГ-т улсын ахлах байцаагч, улсын байцаагч, аймаг, нийслэлд улсын ахлах байцаагч, улсын байцаагч, сум, дүүрэгт улсын байцаагч болон байгаль хамгаалагч нар тус тус ажиллаж байна

4.24. Орон нутгийн МХГ мэргэжлийн боловсон хүчин, техник тоног төхөөрөмж, шинжилгээний лаборатори, бодис урвалж хангалтгүй зэргээс стандартын дагуу сорьц шинжилгээ тэр бүр хийдэггүй байна.

Сав газрын зөвлөлүүд бүрэн эрхээ хэрэгжүүлэн ажиллаж чадахгүй байна.

4.25. 2004 онд шинэчлэн батлагдсан Усны тухай хуулийн 19.1-т “Усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах талаарх нутаг дэвсгэрийн усны

¹⁰ 9.1.2 .рашааныг ашиглахтай шууд холбоогүйгээр барилга байгууламж барих

¹¹ 9.1.3.хог хаягдлын болон бохир ус зайлуулах байгууламж, цэг байрлуулахыг” хориглоно

¹² 34.1.Усны нөөцийн сан бүхий газарт ... халдвар тараах болон ...хог хаягдал, бохирдуулах бодис, үйлдвэрлэлийн бохир ус хаяхыг хориглоно

менежментэд нутгийн иргэдийг оролцуулах зорилгоор гол мөрний сав газрын зөвлөлийг байгуулан ажиллуулна” гэж заасны дагуу БОАЖС-ын 2009 оны 332 дугаар тушаалаар Монгол орны нийт нутаг дэвсгэрийг 29 сав газартай байхаар баталсан байна.

4.26. 2006 оноос хойш гол мөрний 17 зөвлөл байгуулагдсанаас Харнуур-Ховд, Онон, Туул голын сав газрын зөвлөлөөс бусад нь үйл ажиллагаагаа эрхэлж чадахгүй байна.

4.27. Дэлхийн байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр Харнуур-Ховд гол, Онон голын сав газрын зөвлөлүүдийн үйл ажиллагааг санхүүжүүлж, үүнээс Харнуур-Ховд гол усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг боловсруулан БОАЖС-ын 2010 оны А-279 дугаар тушаалаар баталжээ.

4.28. Туул голын сав газрын зөвлөлийн санхүүжилтийг Нидерландын Засгийн газрын буцалтгүй тусламжаар Усны газарт хэрэгжиж буй “Усны нөөцийн нэгдсэн менежментийг бэхжүүлэх” төслийн хөрөнгөөр ивээн тэтгэж, 2010 оноос үйл ажиллагаагаа явуулж байна.

4.29. Тус сав газрын зөвлөлийн ажил дөнгөж эхэлж байгаа бөгөөд Усны тухай хуулиар олгогдсон эрх, үүргээ хэрэгжүүлж, гол бохирдуулсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн буруутай үйл ажиллагааг зогсоох, түдгэлзүүлэх талаар үр дүнтэй ажиллаж чадаагүй байна.

4.30. Энэ нь Усны тухай хуулийн 19-р зүйлд статус, үүрэг хариуцлага тодорхой тусгагдаагүй, БОАЖС-ын 2006 оны 187 дугаар тушаалаар батлагдсан “Гол мөрний сав газрын дүрэм”-д санхүүгийн эх үүсвэрийг заасан хэдий ч хэрэгжихгүй байгаатай холбоотой байна.

4.31. Усны тухай хуулийн 19.4-т “Сав газрын зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, 5-15 гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба түүнд тухайн нутаг, дэвсгэрийн засаг захиргаа, байгаль орчны алба, хөдөө аж ахуй, аж үйлдвэр, төрийн бус байгууллага, иргэд, эрдэмтэн, судлаачид, байгаль хамгаалагч, мэргэжлийн хяналтын алба, усны мэргэжлийн байгууллагын төлөөлөл орсон байна” гэж заасан.

4.32. Гэтэл Ховд Буянт голын сав газрын зөвлөлийн бүрэлдэхүүнд байгаль хамгаалагч болон иргэдийн төлөөлөл ороогүй, Онон голын сав газрын бүрэлдэхүүнд эрдэмтэд, судлаачид болон байгаль хамгаалагч ороогүй бол Туул голын зөвлөл иргэдийн төлөөлөлгүй ажиллаж байна.

4.33. Гол мөрний 17 сав газрын зөвлөлийн дарга нарын 11 нь аймаг, нийслэлийн Засаг дарга болон ЗДТГ-ын албадын дарга нар байна. Сав газрын зөвлөлийн үйл ажиллагаанд олон нийт, ус ашиглагч аж ахуйн нэгж, төрийн бус болон мэргэжлийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэн төрийн захиргаа, байгаль орчны алба, мэргэжлийн хяналтын төлөөлөл буюу ус ашиглагчид эрх олгогч субъектээс хараат бус байдлаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх нь зүйтэй байна.

4.34. Ингэснээр төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, орон нутгийн иргэд, иргэний нийгмийн төлөөлөл, усны мэргэжилтнийг оролцуулсан хяналтын механизм бий болох юм.

4.35. Сав газрын зөвлөлийн бүрэн эрхийг өргөжүүлж, сав газрын хэмжээнд үйлдвэрлэл, уул уурхай болон бусад зориулалтаар ус ашиглан үйл ажиллагаа явуулах иргэн, аж ахуйн нэгжид ус ашиглах эрх олгох болон цуцлах гэх мэт бүрэн эрх олгох нь зүйтэй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын дүнг үндэслэж дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Усны харилцаанд төрийн олон байгууллага оролцож байгаа ч салбар хоорондын зохицуулалт хангалтгүй, нэгдсэн бүтэц, удирдлага, зохион байгуулалт оновчгүй, ажлын уялдаа холбоо хангалтгүй, тус тусдаа салангид бие даасан бодлого хэрэгжүүлж байна.
- БОАЖЯ, Усны газар, аймаг, нийслэлийн БОАЖГ зэрэг усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын ажилтнууд улсын байцаагчийн эрхгүйгээс зөрчил дутагдлыг газар дээр нь таслан зогсоож, шуурхай арга хэмжээ аван, хуулийн хэрэгжилтийг хангуулж чадахгүй байна.
- Усны тухай хууль тогтоомж боловсронгуй бус, зах зээлийн эдийн засгийн нөхцөлд тэр бүр нийцэхгүй, зарим талаар хоорондоо давхардсан буюу зөрчилдсөн бөгөөд усыг ариг гамтай, зохистой хэрэглэх, бохирдлоос хамгаалах, цэвэршүүлэх, дахин ашиглах, усны хангамж, борлуулалтыг сайжруулах зэрэг асуудлыг цогцоор нь зохицуулж чадахгүй байна.
- Монгол орны усны нөөцийг 1971-1975 онд тогтоосноос хойш шинэчлэн тогтоогоогүй бөгөөд тэр үеийн нөөцийн хэмжээг одоо ч түшиглэсээр байна. Гэтэл энэ хугацаанд байгаль, цаг уурын өөрчлөлт, эдийн засгийн өсөлт, зохисгүй хэрэглээ г.м хүчин зүйлсийн нөлөөгөөр усны нөөцийн хэмжээ өөрчлөгдсөн байх магадлал их юм.
- Усны үнэ тариф, түүний дотор уул уурхай, хүнс, хөнгөн үйлдвэрүүдэд ашиглаж буй усны үнэ тариф хямд байгаа нь усны нөөцийг зохистой ашиглах хөшүүрэг болж чадахгүйн зэрэгцээ зах зээлийн харилцааны зарчимд нийцэхгүй байна.
- Гол мөрний сав газрын зөвлөлийн бүрэлдэхүүнд орон нутгийн иргэд, эрдэмтдийн оролцоо, иргэний нийгмийн төлөөлөл хангалтгүй байгаагаас хараат бус хяналтын механизм бүрдээгүй байна.
- Манай орон зах зээлийн нийгэмд шилжсэн боловч нийтээрээ эзэмшдэг ус, түүний экосистемийг хамгаалах үйл ажиллагаанд өөрчлөлт ороогүй, хуучны тогтолцоогоороо байгаа нь гол, горхи, нуур, цөөрмийн хамгаалалд үр дүн гарахгүй байх шалтгаан болж байна
- Аймаг, нийслэлийн хүн амын унд, ахуйн усыг чанаржуулах, арвилан хэмнэлттэй, зүй зохистой ашиглах, тоолууржуулах үйл ажиллагаа хангалтгүй хэрэгжиж, ажлын явц удаашралтай, цэвэрлэх байгууламжууд бохир усыг стандартын түвшинд цэвэрлэх нөхцөл бүрдээгүй байна.
- Аймаг, нийслэлийн хүн амын унд, ахуйн хэрэглээний усны хамгаалалтын бүсийн дэглэмийг зөрчиж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд газар эзэмшүүлэх зөвшөөрөл олгосноор хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж байгаа бөгөөд ус, рашаан ашигласны төлбөрийн орлогын 35 хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлдэггүй, усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулдаггүй байна.
- Усны газар үйлчилгээний хураамжийн орлогыг төсөвт төвлөрүүлэлгүй байгууллагынхаа үйл ажиллагаанд зарцуулж байгаа нь Тэмдэгтийн хураамжийн тухай болон Татварын ерөнхий хуулийг зөрчиж байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтийг үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Монгол Улсын Ерөнхий Сайд С. Батболдод

- Усны үндэсний хороог Ерөнхий сайд буюу эсвэл шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамааруулан, бүрэлдэхүүнийг нь усны салбарын эрдэмтэд, судлаачид, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан өргөжүүлж, салбар дундын зохицуулагчийн эрхтэй болгох асуудлыг судлаж, зохих журмын дагуу шийдвэрлэх.
- Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн ус ашигласны төлбөрийн хувь хэмжээг эргэн хянаж, зарим шаардлагатайг нь нэмэгдүүлэх асуудлыг судлан шийдвэрлэх.
- Усны харилцааг зохицуулахтай холбоотой багц хуулиудыг яаралтай батлуулах асуудлыг анхааралдаа авч шийдвэрлүүлэх.

Байгаль орчин, аялал, жуулчлалын сайд Л.Гансүхэд

- Усны холбогдолтой хууль тогтоомжийг боловсронгуй болгох арга хэмжээг цогц байдлаар төлөвлөж, хэрэгжүүлэх.
- Усны газрын бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгож, чадавхижуулах, мэргэжлийн боловсон хүчнээр хангах асуудлыг судлаж шийдвэрлэх.
- Монгол орны усны нөөцийг шинэчлэн тогтоох ажлыг зохион байгуулах.
- Усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын ажилтнууд улсын байцаагчийн эрхтэй байх хэрэгцээ шаардлагыг судлан, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх.
- Усны тухай хуульд заасан сав газрын зөвлөлийн бүрэлдэхүүнийг оновчтой тогтоох, усны нөөц болон усан орчны баялагийг түүний ойролцоо байнга оршин амьдардаг, өдөр тутам харж хамгаалах боломжтой нутгийн иргэдэд урт хугацаатай гэрээгээр эзэмшүүлэх асуудлыг судлаж, зах зээлийн харилцаанд тохирох хамгааллын тогтолцоо бий болгох чиглэлийг баримтлах.
- Усны нөөцийн ашиглалт, хамгаалалтын байдалтай хэрхэн харилцаж байгаатай нь холбогдуулан хариуцлагын болон урамшууллын тогтолцоог шинэ шатанд гаргах арга хэмжээг авах.

Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулгад

- Аймаг, нийслэлд ашиглагдаж буй цэвэрлэх байгууламжуудад дэвшилтэд технологи нэвтрүүлэх, стандартын шаардлага хангаагүй бохир ус нийлүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хариуцлага тооцох.
- Усны нөөцийг арвилан хэмнэлттэй ашиглах зорилгоор аж ахуйн нэгж, байгууллага иргэдийн усны хэрэглээг тоолууржуулах арга хэмжээ авах, саарал усыг эргүүлэн ашиглах технологийг нэвтрүүлэх асуудлыг шийдвэрлэх.
- Эрдэсжилт хатуулаг ихтэй төв, суурин газрын усыг зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх, чанаржуулах асуудлыг судлаж шийдвэрлэх.

Усны газрын дарга Ц.Бадрахад

- Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд ус ашиглуулах дүгнэлт гаргасны үйлчилгээний төлбөр хураамжийг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн дагуу төсөвт төвлөрүүлж байх.
- Сав газрын зөвлөлийн статус, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгох санал боловсруулж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх.
- Төрийн өмчийн байранд байрлуулж байгаа хувийн өмчийн Усны судалгаа хөгжлийн хүрээлэн ХХК-иас түрээсийн төлбөрийг нөхөн төлүүлэх арга хэмжээг авч, Төрийн өмчийн хороотой гурвалсан гэрээ байгуулж ажиллах.

Холбогдох байгууллагын санал



**МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр,
Утас: 26-61-71, Факс: (976-51) 26-62-86,
E-mail: monenv@mail.mn, http://www.mne.mn

2011.12.16 № 115404

танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР Ч.РАДНАА ТАНАА**

Үндэсний аудитын газраас Монгол орны усны нөөцийн хамгаалалт, ашиглалтын байдалд аудит хийж дүнг нэгтгэн, дүгнэлт, зөвлөмж боловсруулан ирүүлсэнтэй танилцлаа.

Уг тайланд усны салбарт оршиж байгаа дутагдал, бэрхшээл, тулгамдсан асуудлуудыг оновчтой тодорхойлон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар тодорхой дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулсан байна. Дүгнэлт, зөвлөмжид тусгасан асуудлыг цаашдын үйл ажиллагаандаа анхаарч ажиллах болно.

САЙД



Л.ГАНСҮХ

2774



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

УСНЫ ГАЗАР

16050 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,
Чингүнжавын гудамж, Утас: 30-00-75

2011.12.13 № 2а/949
танай _____-ны № _____-т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР Ч.РАДНАА ТАНАА

Тус газраас 2011 онд “Монгол орны усны нөөцийн хамгаалалт, ашиглалтын байдал”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн урьдчилсан дүгнэлт, зөвлөмжтэй танилцаж зөвшөөрч байгаа болно.

Цаашид бид аудитаас өгсөн зөвлөмж дүгнэлтийг хэрэгжүүлж ажиллахад байнгын анхаарал тавин ажиллах болно.

ДАРГА *Ц.Бадрах* Ц.БАДРАХ



081434

Хавсралт 1

№	Аймаг, сумын нэр	Ордын нэр	Ашиглалтын нөөцийн зэрэглэл ба тоо хэмжээ, м³/хоног, (л/с)				Нөөц тогтоосон огноо
			A	B	C ₁	Нийт	
A. Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр							
1	Хэнтий аймаг Өндөрхаан хот	Өндөрхаан	2764.8 (32.0)	2246.4 (26.0)	691.2 (8.0)	5702.4 (66.0)	2008.12.15
2	Завхан аймаг Улиастай хот	Богдын гол	6480 (75.0)	4320 (50.0)	-	10800 (125.0)	2008.12.10
3	Дорноговь аймаг Замын-Үүд сум	Сэвхүүлийн тойром	2635.2	-	2635.2		2007.12.01
4	Сэлэнгэ аймаг Сүхбаатар хот	Орхон	7776.0 (90.0)	5184.0 (60.0)	4320.0 (50.0)	17280.0 (200.0)	2009.02.20
Б. Аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгөөр							
5	Өмнөговь аймаг Цогтцэций сум	Наймантын хөндий	-	3196.8 (37.0)	1382.4 (16.0)	4579.2 (53.0)	2009.01.01
6	Говь-Алтай аймаг Цээл сум	Талын шанд	-	-	4536.0 (52.5)	4536.0 (52.5)	2009.01.01
7	Өмнөговь аймаг Ханбогд сум	Гүний хоолой	-	41774	33393	75168.0	2008.01.01
8	Улаанбаатар хот Хан-Уул дүүрэг	Туул голын хөндий “Нисэхийн усан хангамжийн өнөөгийн эх үүсвэр”-ийн баруун хэсэг	-	15396.5 (178.2)	7153.92 (82.8)	22550.42 (261.0)	2009.01.01
9	Ховд аймаг Мөст сум	Боорчийн гол	-	-	18765.0 (217.0)	18765.0 (217.0)	2009.01.01
10	Дорноговь аймаг Мандах сум	Нарангийн хоолой	-	1278.7 (14.8)	1417.0 (16.0)	2695.7 (31.2)	2009.01.01
11	Дундговь аймаг Өлзийт сум	Хайрхан	-	-	94.7 (1.09)	94.7 (1.09)	2009.01.01
B.Улсын төсвийн хөрөнгөөр							
12	Дархан-Уул аймгийн Шарын гол сум	Буурт		1814	864	2678.4	2011
13	Ховд аймгийн Манхан сумын	Төргөг голын хөндий	2073. 6	2073. 6			2011
14	Сүхбаатар аймгийн төв Баруун-Урт хот	Шовдал-Овоогийн газрын доорхи усны орд	1210	1382.4		2592,0 (30)	2011
БҮГД:			22939.6 (197)	73396.8 (366)	74389.02 (443.39)	162171.42 (1006.79)	

Хавсралт №2

№	Аймгийн нэр	Нуур	Гол, горхи	Булаг, шанд	Рашаан
1	Архангай 7873,4 км ^l	37	20	34	21
	Хамгаалалтын бүсийн тоо: 241	Солбицолын цэгийн тоо 2380			
2	Баян өлгий 4103,4 км ^l	30	15	0	3
	Хамгаалалтын бүсийн тоо: 49	Солбицолын цэгийн тоо: 1686			
3	Баянхонгор 5925,1 км ^l	79	43	23	63
	Хамгаалалтын бүсийн тоо: 143	Солбицолын цэгийн тоо:1236			
4	Булган, Орхон 6072,63 км ^l	69	13	0	4
	Хамгаалалтын бүсийн тоо: 84	Солбицолын цэгийн тоо:1272			
5	Дорнод 6277,25 км ^l	21	76	62	11
	Хамгаалалтын бүсийн тоо: 186	Солбицолын цэгийн тоо: 992			
6	Дорноговь 1359,02 км ^l	1	2	127	179
	Хамгаалалтын бүсийн тоо: 310	Солбицолын цэгийн тоо: 825			
7	Говьсүмбэр Дундговь, 772,78 км ^l	6 2	0 5	16 107	9 29
	Хамгаалалтын бүсийн тоо: 176	Солбицолын цэгийн тоо: 929			
8	Говь-Алтай 9961,78 км ^l	80	39	76	40
	Хамгаалалтын бүсийн тоо: 235	Солбицолын цэгийн тоо: 2913			
9	Хэнтий 1987,44 км ^l	134	80	277	0
	Хамгаалалтын бүсийн тоо: 113	Солбицолын цэгийн тоо: 1727			
10	Ховд 9016,66 км ^l	142	47	196	59
	Хамгаалалтын бүсийн тоо: 447	Солбицолын цэгийн тоо: 3549			
11	Хөвсгөл 1959,65 км ^l	5	63	9	3
	Хамгаалалтын бүсийн тоо:	Солбицолын цэгийн тоо:			
12	Өмнөговь 4110,05 км ^l	0	3	60	66
	Хамгаалалтын бүсийн тоо: 132	Солбицолын цэгийн тоо: 552			
13	Сүхбаатар 3124,27 км ^l	20	56	62	43
	Хамгаалалтын бүсийн тоо: 279	Солбицолын цэгийн тоо: 935			
14	Төв 2643,79 км ^l	63	64	47	4
	Хамгаалалтын бүсийн тоо: 158	Солбицолын цэгийн тоо: 2594			
15	Увс 7856,37 км ^l	57	112	120	7
	Хамгаалалтын бүсийн тоо: 272	Солбицолын цэгийн тоо: 2330			
16	Өвөрхангай 3265,34 км ^l	48	9	77	12
	Хамгаалалтын бүсийн тоо: 148	Солбицолын цэгийн тоо: 1025			
17	Завхан – 9017,64 км ^l	53	164	56	0
	Хамгаалалтын бүсийн тоо: 268	Солбицолын цэгийн тоо: 2643			
18	Дархан Сэлэнгэ 3723,45 км ^l	1 81	14 2	6 4	2 5
	Хамгаалалтын бүсийн тоо: 94	Солбицолын цэгийн тоо: 749			

**Үндэсний аудитын газар болон аймгийн аудитын газраас
илрүүлсэн төлбөр, зөрчлийн жагсаалт**

/сая төгрөгөөр/

№	Аудитын газрын нэр	Товч утга	Төлбөр	Зөрчил	Нийт
1	Үндэсний аудитын газар	ДЦС-II ус ашигласны төлбөрийг төлөөгүй	62.3		62.3
		ДЦС-III ус ашигласны төлбөрийг төлөөгүй	280.9		280.9
		ДЦС-IV ус ашигласны төлбөрийг төлөөгүй	307.7		307.7
	Дүн		650.9		650.9
2	Архангай аймгийн аудитын газар	Ундарга ХХК ус ашигласны төлбөрийг дутуу төвлөрүүлснийг төлүүлэх	2.82		2.82
		Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хувь хэмжээний тухай хуулийн дагуу байгаль хамгаалах санд төвлөрүүлээгүйг төвлөрүүлэх		27.16	27.16
		Усан хангамжийн алдагдлын тооцоог гарган бууруулах арга хэмжээг авснаар гарах үр дүнг тооцох		61.42	61.42
	Дүн		2.82	88.58	91.40
3	Баянхонгор аймгийн аудитын газар	Усны нөөц ашигласны төлбөрийн дутуу ногдуулалтыг төлүүлэх тухай	5.96		5.96
		Усны нөөц ашигласны төлбөрийг төлүүлэх тухай	0.18		0.18
		"Андын тэмүүлэл" ХХК-ны усны ус ашигласны нөөцийн төлбөрийг иргэний дансанд шилжүүлснийг Байгаль хамгаалах санд төвлөрүүлэх тухай		4.00	4.00
	Дүн		6.14	4.00	10.14
4	Булган аймгийн аудитын газар	Эрдэнэт үйлдвэр ус ашигласны төлбөрийг дутуу төвлөрүүлснийг нөхөн төлүүлэх	21.2		21.21
		16 сумын 30 худаг барих ажлыг гэрээний хугацаанд гүйцэтгээгүйд тооцсон алданги	3.4		3.35
		2010 онд Аялал жуулчлал, амралтын газрын зориулалтаар үйл ажиллагаа явуулсан 25 аж ахуй нэгжийн ус ашигласны төлбөрийг дутуу төвлөрүүлсэн	1.5	0.3	1.85
		4 сумын 12 булаг шандны эх хамгаалах ажлын гэрээг дүгнээгүй, хүлээн аваагүйг авах		16.9	16.90
	Дүн		26.1	17.2	43.3
5	Говь-Алтай аймгийн аудитын газар	Тайшир-Гуулин УЦС ХХК нь 2009 2010 оны борлуулалтын орлогод ноогдох усны төлбөрийг орон нутгийн орлогод төлөөгүй	0.78		0.78

		Нийтлэг үйлчилгээний газар нь Хүнхэрийн амралтын газрын 2009, 2010, 2011 оны эхний хагас жилийн орлого ногдуулалтийг орон нутгийн орлогод төлөөгүйг төлүүлэх	0.59		0.59
		Хөгжилтэй андууд хүүхдийн зуслан нь 2009, 2010, 2011 оны эхний хагас жилийн орлого ногдуулалтийг орон нутгийн орлогод төлөөгүйг төлүүлэх	0.32		0.32
	Дүн		1.7	0	1.7
6	Дорноговь аймгийн аудитын газар	Даланжаргалан сумын нутагт Элдэвийн нүүрсний уурхайн ордыг олборлож байгаа Монгол алт ХХК 1 цооног, Хөвсгөл сумын нутаг дах Айл баян нүүрсний уурхайн ордоос олборлолт хийж байгаа Си Өү Эй Эл ХХК 3 цооног гаргахдаа орон нутгийн удирдлагаас зөвшөөрөл авалгүйгээр ус ашиглаж байгаа зөрчилд акт тогтоож, хариуцлага тооцохоор	0.96		0.96
		Айраг сумын нутагт цементийн үйлдвэр байгуулах зориулалтаар 10 цооног гаргасан MIZU LLC ХХК, Даланжаргалан сум нутагт 2 цооног гаргасан Гермес хахиур ХХК-иуд сумын Засаг даргаас зөвшөөрөл авсан боловч тэмдэгийн хураамжийг төлөөгүй	2.88		2.88
		Эрдэнэ суманд хайгуулын үйл ажиллагаа явуулж буй Коммод ХХК, Хатанбулаг суманд үйл ажиллагаа явуулж байгаа Монлаа ХХК-ийн хэрэглэсэн усны төлбөрийг дутуу тооцсоныг нөхөн төлүүлэх	1.2		1.2
		ЭХУХ-ийн II анги ус ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт дутуу төвлөрүүлсэнд	16.8		16.8
		Чандмань Илч ХХК-ийн Айраг суман дахь салбар нь дулаан үйлдвэрлэлд ашигласан ус болон ус хэрэглэгч аж ахуйн нэгж байгууллагад борлуулсан усны төлбөрийг орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлээгүй байсанд	0.555		0.555
	Дүн		22.4	-	22.4
7	Завхан аймгийн аудитын газар	Улиастай эрчим хүч ХХК нь ус ашигласны төлбөрийг төлөөгүй	1.8		1.76
		Завхан мандал сумын УЦС ус ашигласны төлбөрийг төвлөрүүлээгүйг төлүүлэх	0.07		0.07
		РСУАНТ нь ус ашигласны төлбөрийг төвлөрүүлээгүйг төлүүлэх	0.35		0.35
		Тэсийн бүрд ХХК ус ашигласны төлбөрийг төвлөрүүлээгүйг төлүүлэх	0.12		0.12
		Нарантуул Тэс ХХК ус ашигласны төлбөрийг төвлөрүүлээгүй төлүүлэх	1.1		1.12
	Дүн		3.4	-	3.4

8	Орхон аймгийн аудитын газар	Хотын захирагчийн алба цэвэр усны алдагдлыг бууруулах талаар арга хэмжээ авах		82.6	82.62
		Эрдэнэт үйлдвэр ус ашигласны төлбөрийг гүйцэт төлүүлэх		2.0	2.027
	Дүн			84.6	84.6
9	Өвөрхангай аймгийн аудитын газар	Хужирт Элма-Хужирт ХХК ус ашигласны төлбөрийг дутуу төлснийг төлүүлэх	0.24		0.24
		Хужирт рашаан сувилал ХХК ус ашигласны төлбөрийг дутуу төлснийг төлүүлэх	2.18		2.18
		Тарагт Өгөөмөр сувилал ХХК ус ашигласны төлбөрийг дутуу төлснийг төлүүлэх	0.13		0.13
		Тарагт сумын услалтын системийг тайлан тэнцэлд дутуу тусгасныг залруулах		15.5	15.5
	Дүн		2.6	15.5	18.1
10	Сүхбаатар аймгийн аудитын газар	Булгийн эхийг хашиж хамгаалах ажлын гүйцэтгэлийг гаргахдаа илүү тооцож гаргасныг нөхөн төлүүлэх	1.83		1.83
		Онгон сумын “Хавиргын булаг”-ийн эхийг хашиж хамгаалах ажлыг гүйцэтгүүлэхээр “Хонгор говь” ХХК-тай гэрээ байгуулсан боловч одоо хүртэл ажил хийгдээгүйг нөхөн төлүүлэх	5.00		5.00
	Дүн		6.83	0.00	6.83
11	Сэлэнгэ аймгийн аудитын газар	Хөдөө аж ахуйн салбарын ус ашиглалтад ногдуулсан төлбөр	74.19		74.19
		Дулаан, эрчим хүчний үйлдвэрлэлийн ус ашиглалтад ногдуулсан төлбөр	4.80		4.80
		Ус рашаан ашигласны төлбөрийн орлогын 35 хувийг байгаль хамгаалах санд төвлөрүүлэх		169.12	169.12
	Дүн		78.99	169.12	248.11
12	Ховд аймгийн аудитын газар	Инженерийн хийцтэй худаг уст цэг шинээр гаргах, сэргээн засварлах ажил гүйцэтгэх гэрээнд малчдын бүлэг хоршооноос гаргах оролцооны хөрөнгийг дутуу төвлөрүүлж гүйцэтгэгчийг хохироосон		7.51	
				7.51	
	Аймгуудын аудитын газрын дүн		150.90	386.60	529.99
	Нийт дүн		801.80	386.60	1,180.89



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2011 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 133

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

“Төрийн аудитын тухай хууль”-ийн 13.4.5, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23.2, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1.“Монгол орны усны нөөцийн хамгаалалт, ашиглалтын байдал”-д хийсэн аудитын тайланг баталсугай.

2.Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3.Аудитын тайланг Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн Байнгын хороо, Монгол Улсын Ерөнхий сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайд, Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Усны газрын дарга нарт хүргүүлсүгэй.

4.Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2012 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх, Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Усны газрын дарга Ц.Бадрах нарт зөвлөсүгэй.

5.Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д.Ганбилэгт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Ч.РАДНАА

070392
tushaal

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2011 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн
13 дугаар тушаалын хавсралт

Төлбөрийн жагсаалт

УХА0122

(сая төгрөгөөр)

№	Аудитын газрын нэр	Товч утга	Төлбөрийн дүн
1	Үндэсний аудитын газар	ДЦС-II ус ашигласны төлбөрийг төлөөгүй	62.3
		ДЦС-III ус ашигласны төлбөрийг төлөөгүй	280.9
		ДЦС-IY ус ашигласны төлбөрийг төлөөгүй	307.7
	Дүн		650.9